

Хэвлэл мэдээллийн хэрэгслийн эзэмшил, түүний төвлөрлийн асуудал

(Харьцуулсан судалгаа)

М.Доржханд

Нэг. Оршил, уг сэдвийг судлах хэрэгцээ шаардлага

Хоёр. Монгол Улс дахь хууль эрх зүйн орчин

Гурав. Ойлголт, онолын асуудал

- Хэвлэл мэдээллийн эзэмшлийн талаархи ойлголт
 - a. Гадаадын эзэмшил
 - b. Дотоодын эзэмшил
- Хэвлэл мэдээллийн хэрэгслийн төвлөрлийн талаархи ойлголт
- Илт тод (Transparency) байдал түлхүүр ойлголт болох нь

Дөрөв. Гадаад улс орнуудын хууль эрх зүйн орчны харьцуулсан судалгаа

Тав. Хэвлэл мэдээллийн хэрэгслийн эзэмшил, төвлөрлийн талаархи хууль эрх зүйн орчныг бүрдүүлэхэд чиглэгдсэн зөвлөмж, санал дүгнэлт

Нэг. ОРШИЛ

Үг хэлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөө, мэдээлэл олж авах эрхийг бид хэрхэн үнэлж байна вэ? Та хэнээс мэдээлэл сонсч байгаагаа, түүний нөлөөллийг мэдээгүй бол уг мэдээллийн ач холбогдол, үнэ цэнийг ойлгох боломжгүй болно. Улмаар та хэн нэгний ятгалга, дайралт, нөлөөн дор эрхээ эдэлж буйгаа өөрөө ч мэдэлгүй, хөтлөгдөнө гэсэн үг.

Чөлөөт, хараат бус хэвлэл мэдээллийн орчинг бүрдүүлэх нь төслийн хүрээнд судлагдах гол асуудал нь “Хэвлэл мэдээллийн эзэмшил, төвлөрөл”-ийн асуудал байх бөгөөд уг асуудлыг олон улсын болон дотоодын эрх зүйн онол, практикийн түвшинд харьцуулсан судалгааг хийх бөгөөд дараахь байдлаар судалгааны арга зүйг тодорхойлох нь илүү оновчтой гэж үзэж байна. Үүнд:

Судалгааны ажлын зорилго:

Монгол Улс дахь ардчиллыг гүнзгийрүүлэхэд хэвлэл, мэдээллийн хэрэгсэл, түүний зүгээс нөлөөлөх байдлыг судалж, хэвлэл, мэдээллийн эзэмшил, төвлөрлийн ил тод байдал болон түүний зохистой харьцааг тодорхойлсон, эрх зүйн баталгаагаар хангагдсан хэвлэл мэдээллийг хөхиүлэн дэмжснээр хариуцлагатай, сайн засаглалын хөгжлийг дэмжих зорилготой.

Судалгааны хүрээ:

Судалгааны хамрах хүрээг тодорхойлоход хамгийн чухал зүйл бол харьцуулалтын объектыг зөв тодорхойлон гаргах хэрэгтэй.

Хэвлэл, мэдээллийн эзэмшил, төвлөрлийн асуудлын хувьд: Хэвлэл мэдээллийн зах зээлийн хөгжлийн түвшингээр харьцуулан авч үзэх нь хамгийн үндэслэлтэй судалгааг гаргана гэж үзлээ. Үүнд: Хэвлэл мэдээллийн зах зээл хамгийн өндөр түвшинд хөгжсөн улсууд, дундаж, эхлэлтийн шатандаа гэсэн хэсгүүдээр хууль тогтоомжийн харьцуулсан судалгааг хийнэ.

Харьцуулсан судалгаанд хамрагдсан улсууд:

- Англи, Франц, Испани гэсэн хамгийн их ашиг олдог хэвлэлийн компанууд бүхий зах зээл байна. Мөн маш бага үзэгчтэй, үзэгчдийн шууд төлбөр, зар сурталчилгаагаар буюу шууд төлбөрөөр санхүүждэг хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй, бага хүн амтай Шинэ Зелланд зэрэг улсууд байна. Өөрөөр хэлбэл хэвлэл, мэдээллийн эзэмшил, төвлөрлийн асуудал нь түүний **санхүүжилттэй** шууд холбогдож байна.
- Улс болгонд тодорхой хэмжээгээр хэвлэл, мэдээллийн эзэмшил, төвлөрлийн асуудал байгаа учраас олон улсын хэмжээнд хязгаарлах стандарт, зөвлөмжүүдийг судлах нь ач холбогдлоо өгөх юм.
- Зарим улсуудын “Өрсөлдөөний эсрэг” хуульд хэвлэл, мэдээллийн эзэмшил, төвлөрлийг хязгаарласан, хориглосон заалтууд байгаа учраас хууль тогтоомжийн хувьд Хэвлэл, мэдээллийн хууль тогтоомжоос гадна Өрсөлдөөний эсрэг, компанийн тухай хууль зэргийг судлах шаардлага гарна.

- Хэвлэл мэдээллийн эзэмшил, төвлөрлийн асуудал Монгол Улсын хувьд хууль тогтоомжийн болон практик түвшинд ямар хэмжээнд байгааг тодорхойлох, үүссэн асуудлыг олж тодорхойлох хэрэгтэй юм.
- Олон улсын хэмжээний онол, практикийн асуудал:
 - i. Нэр томъёоны болон агуулгын тодорхойлолт, ойлголтын асуудлыг тодорхойлох,
 - ii. Олон улсын стандарт, зөвлөмж
- Судлагдах улсууд: Австрали- хэвлэл, мэдээллийн төвлөрөл ихтэйд тооцогддог улс. Франц: хэвлэл мэдээллийн зах зээл илүүтэй хөгжсөн улсын жишээ. Европын холбоо: Европын холбоо, Евро-парламентаас хэрэгжүүлж буй зохицуулалтын онцлог. Герман: зохицуулалт багатай мэт боловч гадаадын эзэмшлийн асуудал нэлээд яригддаг. АНУ - нэг улсын хэмжээний асуудал биш аль хэдийн дэлхий нийтийг хамарсан асуудал болсон жишээ. Нидерланд, Итали, Австри, Англи зэрэг харилцан адилгүй зохицуулалттай боловч тухайн хэвлэл мэдээллийн зах зээлийн эзлэх хувь, үзэгч, хэрэглэгчдийн тоо, ил тод байдлыг хэрхэн дэмждэг, өрсөлдөөнийг хэрхэн зохицуулдаг, олон төрлийн хэвлэл мэдээллийн хэрэгслийн эзэмшил зэрэг асуудалд ялгаатай болон түгээмэл хандлагууд ажиглагдсан болно.
- Харьцуулсан судалгааны эцэст Монгол Улсад чөлөөт, хараат бус хэвлэл мэдээллийн орчинг бүрдүүлэх талаархи зөвлөмж боловсруулна.
 - o Эх сурвалжийн хувьд өнөөдрийн байдлаар Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомж болон үзэл баримтлал, түүнчлэн холбогдох төрийн бус байгууллагуудын судалгаа /Хэвлэлийн хүрээлэн, Максима, Глоб Интернэшнл-г эх сурвалжаа болгосон. Гадаад улс орны харьцуулалтын хувьд интернэт http://en.wikipedia.org/wiki/Concentration_of_media_ownership , <http://lime.net/resources/netknowledge/meier.pdf>, <http://www.javnost-thepublic.org/article/2010/3/1/> зэрэг эх сурвалжуудыг ашиглалаа.

Хоёр. МОНГОЛ УЛС ДАХЬ ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧИН: хэвлэл мэдээллийн хэрэгслийн эзэмшил, төвлөрлийн эрх зүйн орчин

| Д/д | Монгол Улсын хууль тогтоомж | Заалт | Тайлбар |
|-----|---|--|--|
| 1. | Үндсэн хууль | 16.16 Итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөтэй. 16.17 Төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй. | Үндсэн эрхийг хуульчилсан. |
| 2. | Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай 1998 оны хууль | 4 дүгээр зүйл. Төрийн байгууллагын мэдээллийн хэрэгслийг хориглох: “Төрийн байгууллага өөрийн мэдэлд хэвлэл | Төрийн буюу төрийн оролцоотой байгууллага хэвлэл мэдээллийн хэрэгслийг өмчлөх, эсхүл |

| | | | |
|--|-------------------------------|---|--|
| | | мэдээллийн хэрэгсэлтэй байхыг хориглоно.” | эзэмших асуудлыг хориглосон байж болзошгүй заалт байна. |
| | Харилцаа холбооны тухай хууль | <p>8 дугаар зүйл. Харилцаа холбооны зохицуулах хороо</p> <p>8.1.Өмчийн бүх төрлийн аж ахуйн нэгж, иргэн харилцаа холбооны зах зээлд үр ашигтай, шударга өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлэх, тусгай зөвшөөрөл олгох, мэргэжлийн дүгнэлт, шийдвэр гаргах чиг үүрэгтэй Харилцаа холбооны зохицуулах хороо ажиллана</p> <p>9 дүгээр зүйл. Зохицуулах хорооны бүрэн эрх</p> <p>9.1.2.харилцаа холбооны талаар баримталж буй бодлогын хүрээнд тусгай зөвшөөрөл олгох, түүнийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох, тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагын биелэлтэд хяналт тавих, гэрээ байгуулах;</p> <p>9.1.5.харилцаа холбооны үйлчилгээний тариф тогтоох аргачлалыг батлах, зах зээлд давамгайлж буй үйлчилгээний тарифыг хянах;</p> <p>9.1.6.харилцаа холбооны зах зээлд шударга өрсөлдөх нөхцөл бүрдүүлэх;</p> <p>9.1.8.харилцаа холбооны стандарт боловсруулж, эрх бүхий байгууллагаар батлуулах, хэрэгжилтэд нь хяналт тавих;</p> <p>13 дугаар зүйл. Тусгай зөвшөөрөл авахад бүрдүүлэх баримт бичиг</p> <p>13.1.Иргэн, хуулийн этгээд тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлийг хуульд заасан баримт бичгийн хамт Зохицуулах хороонд ирүүлнэ.</p> <p>13.2.1.санхүү-эдийн засаг, техникийн чадавхи болон мэргэжлийн боловсон хүчний хангалтын талаархи тооцоо, мэдээлэл;</p> <p>13.2.2.хэрэгжүүлэх үйл</p> | <p>Хариуцсан байгууллагатай бөгөөд холбогдох эрх, үүргийг зааж өгсөн боловч бүрэн эрх нь тодорхойгүй, шударга өрсөлдөх нөхцлийг хэрхэн бүрдүүлэх, ямар стандарт барих нь тодорхойгүй, мөн үзэмжээр асуудлыг шийдэх боломж олгож байгаа нь хөндлөнгийн нөлөөлөл, хэвлэл мэдээллийн эрх чөлөөнд сөрөг нөлөө үзүүлж байна.</p> <p>Зах зээлд давамгайлж буй үйлчилгээний тарифыг хянах гэсэн нь мөн л тодорхойгүй.</p> |

| | | | |
|--|--|---|--|
| | | <p>13.2.Тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөлд хууль тогтоомжид зааснаас гадна дараахь бичиг баримтыг хавсаргана:</p> <p>ажиллагааны талаархи мэдээлэл /үйлчилгээний хамрах хүрээ, байршил, технологи, үйлчилгээний тарифын санал/.</p> <p>14 дүгээр зүйл.Тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй гэрээ байгуулах, тусгай зөвшөөрөл олгохоос татгалзах</p> <p>14.1.Тусгай зөвшөөрөл олгосон тохиолдолд Зохицуулах хороо тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй гэрээ байгуулна. Гэрээнд дараахь зүйлийг тусгана:</p> <p>14.1.1.үйлчлэх нутаг дэвсгэр, үйлчилгээний хүртээмж;</p> <p>14.1.2.холбооны шугам, сүлжээний техник, тоног төхөөрөмжийн технологийн үзүүлэлт;</p> <p>Татгалзах нөхцлүүд:</p> <p>15.1.1.харилцаа холбооны хууль тогтоомжийг зөрчсөн, гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй;</p> <p>15.1.4. хууль, гэрээнд заагаагүй үйл ажиллагаа явуулсан.</p> <p>30 дугаар зүйл. Харилцаа холбооны ашиглалт, үйлчилгээ, үйлчилгээнд тавих хяналт</p> <p>30.1.Харилцаа холбооны ашиглалт, үйлчилгээ, үйлдвэрлэлийн үйл ажиллагаа, техник технологийн горимын хэрэгжилтэд улсын байцаагч хяналт тавина.</p> <p>30.2.Улсын байцаагч Төрийн хяналт, шалгалтын тухай хуульд заасан бүрэн эрхээс гадна дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>30.2.1.харилцаа холбооны болон</p> | |
|--|--|---|--|

| | | | |
|----|---|---|--|
| | | <p>радио долгионы тухай хууль тогтоомжийн биелэлт, тусгай зөвшөөрөл олголт, түүний хэрэгжилтийг хянан шалгах;</p> <p>30.2.2.харилцаа холбооны ашиглалт, үйлчилгээ, үйлдвэрлэлд мөрдвөл зохих технологийн горим, тогтоосон стандарт, техникийн нөхцөл болон энэ хуульд заасан бусад шаардлагын биелэлтийг шалгах;</p> | |
| 3. | Радио долгионы тухай 1999 оны хууль | <p>4 дүгээр зүйл. Радио долгионы эзэмшил: “4.1. Монгол Улсын нутаг дэвсгэр дэх үүсгэгчээс үүссэн болон үндэсний радио давтамжийн хуваарилалтын хүснэгтэд багтаж байгаа радио долгион нь Монгол Улсын төрийн өмч мөн. 4.2. Төр нь радио долгион өмчлөгчийн хувьд энэ хуульд заасан нөхцөл, болзолтойгоор радио давтамж, радио давтамжийн зурвасыг ашиглах эрхийг бусад этгээдэд олгоно.”</p> <p>7 дугаар зүйл. Радио давтамжийн зурвас эзэмших эрх бүхий этгээд: “7.1. Нийтийн хэрэглээний радио давтамжийн зурвасыг Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу байгуулагдаж, үйл ажиллагаа явуулж байгаа хуулийн этгээд, иргэн энэ хуулийн дагуу Зохицуулах хорооноос тусгай зөвшөөрөл, эрхийн бичиг авч бүртгүүлж ашиглана.”</p> | <p>Дээрхи заалтуудаас харахад FM, радио долгион ажиллуулж байгаа эзэд нь өмчлөгч биш, эзэмшигч, ашиглагч байх тухай асуудал харагдаж байна. Үүнд Монгол Улсын хуулийн дагуу үйл ажиллагаа явуулж буй иргэн /гэхдээ гадаадын эсхүл харьяалалгүй этгээд байж болох асуудал харагдаж байна./, Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу байгуулагдсан дотоодын болон гадаадын хөрөнгө оруулалттай ямар ч хуулийн этгээд байж болох аж.</p> |
| | Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль | <p>15.16. Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн чиглэлээр:</p> <p>15.16.1. радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах;</p> <p>15.16.2.харилцаа холбооны үйлчилгээний сүлжээ байгуулах, түүний ашиглалт, үйлчилгээ эрхлэх.</p> | |
| 4. | Өрсөлдөөний тухай хууль | <p>4.1.9.“зах зээлийн төвлөрөл” гэж зах зээлд аж ахуй эрхлэгчийн дангаараа буюу бусад этгээдтэй хамтран, эсхүл харилцан хамаарал бүхий этгээдийн борлуулж байгаа тухайн бараа бүтээгдэхүүний эзлэх хувийг;</p> <p>5.2.Тодорхой бараа бүтээгдэхүүний зах зээлд дангаараа буюу бусад</p> | <p>Зах зээлийн төвлөрөл гэх ойлголтыг тодорхойлсон боловч хэвлэл мэдээллийн хэрэгслийн эзэмшигчдийн төвлөрлийн асуудлыг хэрхэн зохицуулах нь ойлгомжгүй.</p> |

| | | | |
|----|---|--|---|
| | | <p>этгээдтэй хамтран, эсхүл харилцан хамаарал бүхий этгээд үйлдвэрлэл, борлуулалтын, эсхүл худалдан авалтын гуравны нэг буюу түүнээс дээш хувийг эзэлж байвал давамгай байдалтай аж ахуй эрхлэгч гэж үзнэ.</p> <p>5.3.Энэ хуулийн 5.2-т заасан хувьд хүрээгүй ч бусад аж ахуй эрхлэгчийг зах зээлд гарч ирэх нөхцөлийг хаан боогдуулах, зах зээлээс шахан гаргах чадвартай аж ахуй эрхлэгчийг бараа бүтээгдэхүүний хүрээ, зах зээлийн газар зүйн хил хязгаар, зах зээлийн төвлөрөл, зах зээлийн хүч зэргийг үндэслэн давамгай байдалтай гэж үзэж болно.</p> <p>14 дүгээр зүйл. Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар</p> <p>14.1.Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар нь өрсөлдөөний тухай хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих, өрсөлдөөний бодлогыг улсын хэмжээнд хэрэгжүүлэх, аж ахуй эрхлэгч, хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах чиг үүрэг бүхий төрийн захиргааны байгууллага мөн.</p> | <p>Харилцаа холбооны зохицуулах газар болон Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын чиг үүрэг нь давхцсан.</p> |
| 6. | <p>Үзэл баримтлал батлах тухай УИХ-ын 2000 оны 21 дүгээр тогтоол</p> | <p>II. Эдийн засаг-бизнесийн хүрээнд тавих зорилт: “26. Зах зээлд шударга өрсөлдөөн оршин тогтнох мэдээллийн ил тод орчин бий болгох.”</p> <p>III. Хүний хөгжлийн хүрээнд тавих зорилт: “8. Иргэд мэдээллийн чөлөөтэй олж авах тогтолцоог бий болгох.”</p> | <p>2010 он хүртэлх үзэл баримтлал хэмээн заасан.</p> |
| | <p>Харилцаа холбооны зохицуулах хорооны 2009 оны 40 дүгээр тогтоолын хавсралт</p> <p>(Монгол Улсын харилцаа холбооны зохицуулах</p> | <p>2.3. Радио, телевизийн өргөн нэвтрүүлэг: Радио, телевизийн зах зээлийн өрсөлдөөний таатай орчинг бүрдүүлэх, үйл ажиллагааны зарчим, хэм хэмжээг тогтоон мөрдүүлнэ.</p> | <p>Тодорхойгүй</p> |

| | | | |
|----|---|---|--|
| | хороо харилцаа холбооны зохицуулах хорооны 2009-2012 оны үйл ажиллагааны стратеги улаанбаатар хот 2009 | | |
| 7. | 2010 оны 5 дугаар сарын 11-12-нд зохион байгуулагдсан “Харилцаа холбооны зохицуулалт 2010” форумаас гаргасан бизнесийн орчны шинэчлэлийг бий болгох үр ашигтай зохицуулалтын талаархи зөвлөмж | <p>III. Радио, телевизийн өргөн нэвтрүүлгийг хөгжүүлэх асуудлаар: Зохицуулалтын хүрээнд:</p> <p>2.3. Хувь эзэмшигчийн ил тод байдал /Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн төсөлтэй уялдуулах/</p> <p>5. Стандарт, тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагыг шинэчлэн тогтоох</p> | Уг бичиг баримт нь зөвлөмжийн шинжтэй бөгөөд Харилцаа холбооны зохицуулах газраас авч хэрэгжүүлж буй алхмын нэг юм. |
| 8. | УИХ-ын 2010 оны 48 дугаар тогтоол. “Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал батлах тухай” | <p>3.3.4. Нийгмийн тогтвортой байдал</p> <p>3.3.4.3. Хэвлэл мэдээллийн хараат бус, бие даасан байдлыг бэхжүүлж, хариуцлагатай, мэргэшсэн сэтгүүл зүй, сэтгүүлчийн ёс зүйн хэм хэмжээг төлөвшүүлж, нийгмийн тогтвортой байдлыг хангана.</p> <p>3.6. Мэдээллийн аюулгүй байдал Мэдээллийн салбарт үндэсний ашиг сонирхлыг хамгаалах, төр, иргэн, хувийн хэвшлийн мэдээллийн бүрэн бүтэн, нууцлагдсан, хүртээмжтэй байдлыг баталгаажуулах нь мэдээллийн аюулгүй байдлыг хангах үндэс мөн.</p> <p>3.6.1.4. Монгол Улсад гадаадын хөрөнгө оруулалттай хэвлэл мэдээллийн хэрэгсэл үндэсний аюулгүй байдалд харшилсан үйл ажиллагаа явуулбал <u>үйл ажиллагаа явуулах эрхийг хязгаарлаж болно.</u> Хэвлэл мэдээллийн хэрэгслийн эзэмшил, харъяалал нь ил тод байх</p> | Эзэмшил, харъяаллын асуудлыг ил тод болгоно гэсэн үндсэн суурийг тавьснаас гадна, хэрэв гадаадын эзэмшил болон үүнтэй холбогдох асуудал нь үндэсний аюулгүй байдалд харшилбал хязгаарлаж болно гэж заасан байна. |

| | | | |
|--|---|---|--|
| | | <p>бөгөөд үйл ажиллагаа нь бодитой, тэнцвэртэй, хариуцлагатай байна. Мэдээллийн хэрэгслээр үндэсний үнэт зүйлийг түлхүү нийтлэх, сурталчлахыг дэмжиж, гадны шашин, соёл, төрийн бодлогыг сурталчилсан агуулгатай мэдээллийг зохистой түвшинд хязгаарлана.</p> <p>3.6.1.8. Өрсөлдөх чадвартай мэдээлэл, харилцаа холбооны систем, техник хэрэгсэл, программ хангамжийн үндэсний үйлдвэрлэл болон мэдээллийн аюулгүй байдлын шийдэл боловсруулах ажиллагааг дэмжин хөгжүүлж технологийн хараат байдлыг бууруулна.</p> | |
| | Засгийн газрын 2010 оны 275 дугаар тогтоол “Үндэсний хөтөлбөр батлах тухай” | Энэхүү тогтоолоор Радио, телевизийн өргөн нэвтрүүлгийг тоон технологид шилжүүлэх үндэсний хөтөлбөр, үйл ажиллагааны төлөвлөгөөг баталсан байна. Уг баримт бичигт эзэмшил, төвлөрлийн талаархи холбогдох нарийвчилсан заалт ороогүй байна. | |
| | Засгийн газрын 2010 оны 276 дугаар тогтоол “Телевиз радиогийн зохицуулалтын талаар баримтлах чиглэл батлах тухай” | <p>2. Телевизийн хөрөнгө оруулагч, эзэмшигч, удирдлагын талаархи мэдээллийг олон нийтэд ил тод болгох.</p> <p>3. Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-ын 3.2.2.2¹-т заасан чиглэлийг баримталж ажиллах.</p> <p>8. Телевизэд тусгай зөвшөөрөл олгохдоо нэвтрүүлгийн нийт агуулгын 50 хувиас доошгүйг нь үндэсний эрх ашиг, соёл, хэл, зан заншил, хүүхдэд зориулсан нэвтрүүлэг, Монгол Улсад бүтээсэн бүтээл байх зохицуулалтыг гэрээнд тусгаж байх.</p> | Энд гадаадын эзэмшлийн талаархи заалтыг тусгасан байна. |
| | Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенц | <ul style="list-style-type: none"> • НҮБ-ийн хүний эрхийн түгээмэл тунхаглал • Иргэний болон улс төрийн эрхийн тухай Олон улсын Пакт, 1974 • Зохиогчийн эрхийн тухай Дэлхийн оюуны өмчийн байгууллагын гэрээ (1996)-2002 | Монгол Улс үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг илэрхийлсэн заалтуудыг хүлээн зөвшөөрч, хууль тогтоомждоо тусгасан боловч хэрхэн хэрэгжүүлэх, хамгаалах, уялдуулах талаархи заалт хангалтгүй. |

Дүгнэлт, санал:

1. Төрийн эрх бүхий албан тушаалтан /УИХ-ын гишүүн, Засаг дарга гэх мэт/, төрийн өмчит үйлдвэрийн газар өөрийн хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй байх, түүнийг өмчлөх, эзэмших асуудал байж болохыг үгүйсгэх, хориглох, ил тод болгох хууль эрх зүйн орчин байхгүй.
2. Тусгай зөвшөөрөл авахад бүрдүүлэх материалд эзэмшигчийн талаархи мэдээллийг мөн оруулсан мэдээллийг гаргуулах, мөн уг эзэмшигч нь хэвлэл мэдээллийн өөр хэрэгсэл эзэмшиж байгаа эсэх зэрэг мэдээллийг гаргуулах хэрэгтэй. Ингэснээр Зохицуулах хороо болон байцаагч нь хянаж шалгах, холбогдох стандарт дүрэм журам боловсруулах үүрэгээ хэрэгжүүлэх боломжтой болох юм. Мөн тусгай зөвшөөрөл олгохоос үндэслэл, шалгуур нь ч байх боломжтой.
3. Харилцаа холбооны зохицуулах хороо, Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн эрхийн төлөө газар хоорондын хамтын ажиллагааг баталгаажуулах шаардлагатай.
4. Хуулийн зохицуулалтыг уялдуулах арга хэмжээ, хэрэгжүүлэх арга замыг тодорхойлох нь зүйтэй.
5. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын талаархи шинэчилсэн үзэл баримтлал болон зөвлөмж, холбогдох баримтуудаар Монгол Улс дахь хэвлэл мэдээллийн хэрэгслийн эзэмшлийг ил тод болгон гэдгийг зөвшөөрч баталгаажуулж байгаа нь сайшаалтай байна. Гэвч үүнийг ил тод болгох шалгуур, зах зээлийн судалгаанд үндэслэсэн зохицуулалт хамгийн чухал юм.
6. Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд тусгагдсан эзэмшил, харъяаллын асуудлыг ил тод болгох тухай асуудал болон гадаадын эзэмшил болон үүнтэй холбогдох асуудал нь үндэсний аюулгүй байдалд харшилбал хязгаарлаж болно гэж заасан асуудлыг хуулийн заалт байдлаар хуульчлан тогтоож, хэрхэн ил тод болгох асуудал зэргийг Харилцаа холбооны зохицуулах газраас гаргах журмуудаар гаргаж болох боловч тусгай зөвшөөрөл авах суурь нөхцөл болгон хуульд тусгах нь зүйтэй юм.
7. Харилцаа холбооны зохицуулах газраас радио телевизийн ерөнхий зохицуулалт, холболтын журам, тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлага зэргээр нарийвчилсан журмууд гаргахаар ажиллаж байна.

Гурав. ОЙЛГОЛТ, ОНОЛЫН АСУУДАЛ

Хэвлэл мэдээллийн хэрэгслийн төвлөрлийг олон янзаар тодорхойлж болно. Европын Зөвлөлөөс тайдбарлахдаа уг ойлголтыг олон ургалч үзэл гэх ойлголттой эсрэгцүүлэн тавьсан байна. Үүнд:

Олон ургалч үзэл гэдэг нь хэвлэл мэдээллээр дамжуулан илэрхийлэх нийгэм, улс төр, соёлын өргөн хэмжээний үнэлэмж, үзэл бодол, мэдээлэл, ашиг сонирхлын хүрээ гэсэн утгатай гэж ойлгодог.

Олон ургалч үзэлын энэхүү тодорхойлолт нь хэвлэл мэдээллийн хэрэгслийн төвлөрлийг олон ургалч үзэлтэй эсрэгцүүлэн үзэж байна. Энэ нь хэвлэл мэдээллийн хэрэгслийн төвлөрлийн тодорхойлолтыг логикийн хувьд нэлээд “негатив” болгож байна.

Олон ургалч үзлийн "ЗХУ-ын шалгуур". Дээр иш татсан тодорхойлолтоос үзвэл төвлөрөл бол компаниудын бүтэц, зохион байгуулалттай холбоотой бус харин хэвлэл мэдээллийн хэрэгслийн **агуулга**-тай холбоотой. Энэ нь тодорхой хэмжээгээр уг ухагдахууны одоогийн ойлголтоос гажиж байгаа юм. Гэхдээ ингэж гажих томоохон шалтгаан бий. Учир нь хэвлэл мэдээллийн хэрэгслийн бүтцэд анхаарал хандуулсан тодорхойлолтууд “төвлөрсөн бүтцэд хамаардаггүй хэвлэл мэдээллийн компаниуд тэгэхээр плюралист” гэсэн эсрэг утгыг агуулах эрсдэлтэй юм. Үүний олон жишээ баримтыг Европын хуучин дарангуйллын дэглэмийн хэвлэл мэдээллийн бүтэц зохион байгуулалтаас олж үзэж болно. Жишээлбэл, хуучин ЗХУ-д олон байгууллага, компаниудад сонин сэтгүүл хэвлэн нийтлэхийг зөвшөөрдөг байв. Гэхдээ мэдээж хэрэг Европын Хүний эрхийн Конвенцид тодорхойлсон хүний эрхий тухай нийтлэг ойлголт шиг “олон ургалч үзэл” бодитой зүйл биш байв. Зөвлөлтийн орнуудын механизм, бүтэц нь хэвлэл мэдээллийн хэрэгслийн жинхэнэ эрх мэдлийг цорын ганц нэгж болох Коммунист намд төвлөрүүлж байв. Зарим иргэд, ялангуяа гадаад хэлний зохих мэдлэгтэй иргэд албан ёсны сувгуудаас өөр мэдээллийн сувгуудад хүрэх боломжтой байжээ.

Хэвлэл мэдээллийн хэрэгслийн төвлөрлийн талаарх Европын холбооны нийтлэг хандлага

Европын Зөвлөл. Европын Зөвлөл хэвлэл мэдээллийн хэрэгслийн салбарт үйл ажиллагаа явуулахдаа үзэл бодол, мэдээллийн эрх чөлөөтэй холбоотой Хүний эрхийн Европын Конвенцийн 10-р зүйлийг үндэслэдэг. Өнөөдөр олон нийтийн мэдээллийн хэрэгсэл бол үзэл бодлоо илэрхийлэх энэхүү системийн салшгүй нэг хэсэг болсон бөгөөд Зөвлөлийн гишүүн орон бүрт үг хэлэх эрх чөлөө бодитоор хэрэгжихгүй бол тус байгууллагын ардчилсан туйлын зорилгод эрсдэл учруулна гэж үздэг байна.

Гишүүн орнууд нь баталсан багц конвенцоороо дамжуулан Европын нийтлэг хууль тогтоомжийг тодорхой түвшинд хүргэхэд Европын Зөвлөл үүрэг гүйцэтгэсэн. Хэвлэл мэдээллийн хэрэгслийн салбарт мөн тодорхой конвенциуд байдаг – хамгийн алдартай нь Европын Нийгэмлэгийн хууль болох *Хил Хязгааргүйн Телевиз*-ээс өмнөхөн батлагдсан *Хил дамнасан Телевизийн тухай Конвенци* юм.

Европын Зөвлөлийн, нэн ялангуяа Тамгын газрын зорилго нь Европын хууль тогтоомжийн уялдаа холбоог хангах хэрэгсэл болох явдал юм. Энэ нь Европын Холбооны илүү хүчирхэг зохион байгуулалт, зорилгуудын дэргэд тийм ч бодитой зүйл биш юм. Харин түүний оронд тус Зөвлөл бодлого журмын хэлэлцүүлэг, анализ, судалгааны агентлагийн үүрэг илүүтэй гүйцэтгэж байна. Энд дурдсан асуудлуудын хувьд энэ үүрэг нь албан ёсны хууль тогтоох үйл ажиллагаатай адил эсвэл бүр илүү чухал болж байгаа юм.

Тус Зөвлөл хэвлэл мэдээллийн хэрэгслийн төвлөрлийн талаарх одоогийн хэлэлцүүлэг зөвлөгөөнөө 1989 онд эхэлжээ. Тэдний зорилго нь хил дамнасан телевизийн конвенцид дурдсаны дагуу нийтлэг зохицуулалтын санаачилга бий болгох тодорхой улс төрийн гэрээ хэлэлцээр хийх явдал байв. Энэ нь Тамгын газар ба Зөвлөлийн хэвлэл

мэдээллийн хэрэгслийн байнгын хорооны (CDMM) хамгийн идэвхтэй зарим орнуудын хувьд аль алинд нь урам өгсөн хүчин зүйл байлаа.

Эхний үед “олон ургалч үзэлын зорилготой холбоотойгоор бие даасан улс орнууд дахь хэвлэл мэдээллийн хэрэгслийн бүтэц ба эзэмшлийн хөгжил, өөрчлөлтүүдийн үр дагаврын нийтлэг орчинг судлах” гэсэн маш энгийн төлөвлөгөөтэй байв.

Эрхзүйн болон бүтцийн асуудлыг аль алийг нь тусгасан цуврал асуулгыг Гишүүн орнуудад тараасан бөгөөд энэхүү асуулгын хариултанд анализ хийж үр дүнг нь тайлагнах ажилд хоёр зөвлөх томилсон байна. Уг ажлыг хянах, тайланг бэлтгэх ажлын хэсэг байгуулжээ.

Гэтэл нарийн, баримттай тайлан гаргах нь асар их хүч шаардсан ажил болох нь тодорхой болжээ. Зөвлөхүүд их хэмжээний баримт бичиг, анализ, хууль тогтоомжийн тухай судалгаа гаргасан боловч хэд хэдэн Гишүүн орон уг аргазүйд эргэлзэж байгаагаар илэрхийлээд төсөлд үзүүлэх дэмжлэгээ буцаан татсан байна. Мөн илүү нарийн судалгаа хийхэд улс төрийн эсэргүүцэлтэй тулгарч байсан ба нэн ялангуяа Их Британийн засгийн газар хэвлэл мэдээллийн хэрэгслийн төвлөрлийн асуудал байдаг гэдгийг няцааж уг төсөлд эргэлзээ тогтмол бий болгож байв. Ингээд анализ хийсэн, цогц тайлан хэвлэгдэн гараагүй боловч олон үйл явдлын үеэр ихээхэн хэмжээний бичиг баримт Хороонд цугларсан байна.

Ингээд одоогоор Европын Зөвлөл хэвлэл мэдээллийн хэрэгслийн төвлөрлийн асуудлын олон талт судалгаа, мэдээлэл, тойм бэлтгэн гаргасан үр дүнтэй байна. Зөвхөн нэг зохицуулалтын баримт бичиг нь батлагдсан нь 1994 оны Ил тод байдлын тухай зөвлөмж юм.

Европын Холбоо. Хожим нь Европын Холбоо болсон Европын Хамтын Нийгэмлэг нь хэвлэл мэдээллийн хэрэгслийн төвлөрлийн тухай асуудалд Европын Зөвлөлөөс өөр өнцгөөс ханддаг. ЕЗ үүнийг эдийн засгийн нэгдэл, Европын дотоодын зах зээлийн үүсгэн байгуулалтын талаас хардаг.

1980-аад оны сүүл үеэс хойш Европын Парламент хэвлэл мэдээллийн хэрэгслийн эзэмшлийн өсөн нэмэгдэж буй төвлөрлийг бууруулах санал санаачилга гаргахыг уриалжээ. Энэ нь анх Германы Социал демократууд болон хэвлэлийн газруудын үйлдвэрчний эвлэлээс гарсан байна. Комисс энэхүү санаачлагын хариуд 1992 оны сүүлээр Дотоодын Зах зээл дэх Хэвлэл мэдээллийн хэрэгслийн Төвлөрөл ба Олон ургалч үзэлын тухай “Green Paper” нийтлэн гаргажээ. Урт хугацааны туршид зөвлөгөөн, маргаан хийж улсын болон улс дамнасан томоохон хэвлэл мэдээллийн группуудээс лобби хийсний дараа 1996 оны 7-р сард Төлөөлөгч Марио Монти хамтран ажиллагсаддаа захирамж тогтоолын бичиг танилцуулахад бэлэн болсон байна.

Энэхүү бичиг нь албан бус хэдий ч Гишүүн орнууд болон сэтгүүлчдэд аль алинд нь танилцуулсан аж. Харин 1996 оны 9-р сарын 4-нд болсон уулзалтын үеэр Төлөөлөгчид төслийг буцааж нэмэлт өөрчлөлт хийхийг хүсчээ. 1997 оны хавар дараачийн хувилбар нь гарсан. Ноён Монтигийн төслийг Германы нөлөө бүхий Төлөөлөгч Бангеманн дэмжсэн хэдий ч түүнээс хойш хэлэлцүүлэг үргэлжилсээр шийдэлд хүрээгүй хэвээр байна.

1997 оны 8 дугаар сард Германы канцлер Хелмут Кол Комиссын Ерөнхийлөгчид захиа явуулж энэ бол улс үндэстний хууль тогтоомжийн асуудал хэмээн нийтлэг дүрэм журамтай байх тухай төслийг бүхэлд нь эсэргүүцэж буйгаа илэрхийлсэн нь уг процессийг шинэ шатанд аваачжээ. Хэвлэл мэдээллийн салбарын лобби группүүдээс дарамт ирсээр байв. Лобби бүлгээс тарааж байх магадлалтай байнгын цуу яриаг үл харгалзан Комисс төсөл дээр үргэлжлүүлэн ажиллаж, албаны хүмүүс нь уг санаачилгыг хэрэгжүүлэхэд өөдрөгөөр хандсан хэвээр байгаа ч одоогийн байдлаар Европын нийтлэг хэлэлцээрийн хэтийн төлөв сайнгүй харагдаж байна. Захирамж тогтоолын төслийг өргөн баривал түүний дараа хэлэлцүүлэг олон жил үргэлжилнэ гэдэг нь тодорхой юм. Санаачилгыг танилцуулснаас хойш Гишүүн орнуудад эрхзүйн баримт бичгийг батлах ажил 10 жилээс багагүй хугацаа зарцуулах нь дамжиггүй. (Швед улсын хувьд хэвлэл мэдээлэл, кабелийн радио, телевизийн эзэмшилд хязгаарлалт тогтооход аливаа онцгой хууль тогтоомж батлахаас өмнө хэвлэл нийтлэх эрх чөлөө, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний тухай үндсэн хуулинд нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатай болно.)

Одоо мөрдөж буй баримт бичиг нь өнөөгийн хэвлэл мэдээллийн орчин нөхцөлд нийцдэггүй хэдий ч комиссийн дотоод хэлэлцүүлгээр боловсруулсан дүрэм журамд олон сонголт боломж агуулсан хэвээр байна гэж Комисс баталж байна. Тэдгээр дүрэм журмыг дараах 2 энгийн зарчим дээр үндэслэжээ:

1. Радио эсвэл телевизийн хэвлэл мэдээлийн нэг байгууллагын эзэмших үзэгчдийн хувь хэмжээний дээд хязгаар нь тухайн захиргааны нэгж дэх нийт үзэгчдийн 30% байх ёстой.
2. Радио, телевиз, сонины үзэгч/уншигчдын нийт хувь хэмжээ 10%-иас давах ёсгүй.

Эзэмшилийн тухай удирдамжийн өөр нэг сонголт нь дээд хувь хэмжээг зааж өгөхийн оронд хэвлэл мэдээллийн эзэмшилийн ил тод байдлыг сайжруулах явдал юм. 1997 оны 11-н сарын 27-нд Мэдээллийн нийгмийн үйлчилгээний ил тод байдлын механизмтай холбоотой удирдамжийн асуудалд “нийтлэг байр сууринд” хүрчээ.

Хэвлэл мэдээллийн хэрэгслийн төвлөрөл ба олон ургалч үзэлийн тухай Европын бодлого

Хэвлэл мэдээллийн хэрэгслийн төвлөрлийн тухай бодлого журмыг доорх байдлаар ангилж болно:

1. Хориг хязгаарлалт
2. "Тэнцвэржилт"
3. Эдийн засгийн оролцоо
4. Ил тод байдлын арга хэмжээ
5. Зохион байгуулалтын арга хэмжээ

Энэхүү ангиллууд бусдаасаа бүрэн тусгаар байж болохгүй: дүрэм журмын хувьд хориг хязгаарлалт нь бусад бүх ангилалд үүрэг гүйцэтгэх ба дүрэм журам зэрэг аливаа хэлбэрийн улс төрийн арга хэмжээнд зохион байгуулалтын гүйцэтгэл тодорхой хэмжээгээр шаардагдана.

1. Хориг хязгаарлалт. Хориг хязгаарлалтыг 2 ялгаатай ангилалд хувааж болно: хуулиар тогтоогдсон (дүрэм журам) ба сайн дурын. Онолын үүднээс олон нийтийн удирдлагаас гаргасан бүх төрлийн дүрэм журмыг тухайн секторт (бүх зүйл эрх тэгш байхад) оролцогчид буюу өрсөлдөгчид хэлэлцэн тохирсон хориг хязгаарлалтаар орлуулж болно. Харин практикт хориг хязгаарлалт ихэвчлэн хуулиар тогтоогдсон байдаг. Нэг шалтгаан нь өрсөлдөөний тухай дүрэм журам нь ерөнхийдөө зах зээлд оролцогчид бүрэн хөгжсөн өрсөлдөөнийг хязгаарлах гэрээ хэлцэл хийхийг оролдохгүй байх урьдчилсан нөхцлийг таамагладаг.

1.1. Дүрэм журам

Ерөнхий

Ихэнх улс орны үндсэн хуулинд үзэл бодлоо илэрхийлэх ба мэдээлэл дамжуулах эрх чөлөөний тухай, мөн олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэлд олон ургалч үзэлыг дэмжих шаардлагыг дор хаяж шууд бус утгаар ч болов дурдсан байдаг. Зарим үндсэн хуулинд улсаас ард иргэдэд тодорхой хэмжээний мэдээллээр хангах үүргийг зааж өгсөн байдаг (Германы *Grundversorgungspflicht*).

Ихэнх улс орон хэвлэл мэдээллийн салбартаа өрсөлдөөн зохицуулах хууль тогтоомж мөрддөг. Гэхдээ үүнд хамаарахгүй тохиолдлыг дурдах нь зүйтэй. АНУ-ын хууль тогтоомжоор сонинууд хоорондоо зарим талаар хамтран ажиллахыг зөвшөөрдөг. Европын Холбооны Компаниудын Нэгдлийн тухай Дүрмээр “хэвлэл мэдээллийн хэрэгслийн плюрал байдал”-ын шалтгааны улмаас “Европын” хэмжүүрт хүрсэн компаниуд хоорондын нэгдлийг зохицуулах Хамтын нийгэмлэгийн байгууллагуудын онцгой эрхээс чөлөөлдөг.

Тусгай

Олон улс орнууд суваг (Итали, Португал, Испани, Швед), үзэгчдийн хувь хэмжээ (Их Британи, Герман, Франц), хэвлэл нийтлэлийн салбарт борлуулалтын хувь хэмжээ эсвэл нийт борлуулалт (Франц, Их Британи), гадаад эзэмшигчийн хувьцаа (Польш), нэг сувгийн эзэмших хувьцаа (Норвеги), сонгох эрх (Швед) зэргийн дээр тоонд үндэслэн хэвлэл мэдээллийн хэрэгслийн хяналтанд тооны хязгаар тогтоодог. Энэ төрлийн хязгаарлалтуудыг нэг төрлийн хэвлэл мэдээллийн хэрэгсэлд хамаарах буюу эзэмшилийн тодорхой нэгдлийг хязгаарлах замаар зохион байгуулсан байж болно (ж нь: Итали, Их Британи, Швед).

Зарим улс орнууд хэвлэл мэдээллийн холдингтой холбоотой ерөнхий заалттай байдаг (Норвеги), зарим нь тусгай зөвшөөрөл олгох процедурын шийдвэрт нөлөөлөх ерөнхий зүйлд (“олон нийтийн ашиг сонирхол”) анхаарал хандуулахыг зөвшөөрдөг (Герман, Их Британи).

1.1.1. Сайн дурын гэрээ хэлцэл

Хэвлэл мэдээллийн хэрэгслийн эзэмшил ба бүтцийн салбарт оролцогч нар компаниудын нэгдэлтэй холбоотой сайн дурын гэрээ хэлцэл хийх нь ховор байдаг. Харин Нидерландын үндэсний хэвлэлийн салбарт хэвлэл мэдээллийн хэрэгсэл эзэмшигчид үндэсний хэвлэлийн салбарын гуравны нэгээс дээш хэмжээний хувийг эзэмшихгүй байх гэрээ хийсэн байна. Мэдээж хэрэг энэ төрлийн хориг хязгаарлалтанд зах зээлийг хуваах олон төрлийн бичигдээгүй хэлцлийг оруулж болно. Гэхдээ хэвлэл мэдээллийн хэрэгслийн

бүтцэд ихээр нөлөөлдөг хэдий ч эцсээ хүртэл өрсөлдөхгүй байх шийдвэрийг олон ургалч үзэлыг хөгжүүлэх арга зам гэж бараг үздэггүй, харин ч эсрэгээр энэ нь орон нутгийн монополичлолийг бэхжүүлдэг. Өрсөлдөгчид хоорондоо хамтрах замаар борлуулалт, цацалтын үнийг бууруулах систем байдаг бөгөөд Шведэд энэ төрлийн борлуулалтанд төрөөс татаас олгодог.

Хэд хэдэн оронд (Австри, Бельги, Герман, Норвеги г.м) редакцийн ажилтнууд эзэмшигчээс хараат бус байх тухай гэрээг эзэмшигч, сэтгүүлчдийн хооронд байгуулдаг уламжлал байдаг тухай дурдах нь зүйтэй болов уу. Энэ нь эзэмшигчийн үйл ажиллагааны хүрээг тодорхой хэмжээгээр хязгаарлаж тухайн байгууллага дотор нэг төрлийн олон ургалч үзэлыг бий болгоход тусалдаг. Зарим тохиолдолд (Бельги гэх мэт) сониныг худалдан авахад шинэ эзэмшигч нь ажилтнуудтай тохиролцдог байна.

2. Тэнцвэржилт. Энэ нэр томъёо нь үг сонголтын хувьд тийм ч оновчтой биш байж болно, гэхдээ чөлөөт зах зээлийн буюу арилжааны хэвлэл мэдээллийн хэрэгслээс өөр сонголт болох олон нийтэд чиглэгдсэн хэвлэл мэдээллийн хэрэгслийн ойлголтыг тайлбарлах зорилготой юм.

2.1. Олон нийтийн үйлчилгээний радио, телевиз

Олон нийтийн мэдээллийн хэрэгслийн орлогын хууль ёсны эх сурвалж нь зар сурталчилгаа байдаг, тиймээс мэдээж хэрэг энэ нь зар сурталчилгааны зах зээл дээр олон нийтийн болон хувийн операторуудын дунд шууд өрсөлдөөн бий болгодог. Нэг талыг баримтлаагүй мэдээ мэдээлэл дамжуулах тухай дүрэм журам, хөтөлбөрийн олон талт агуулга, улс төрийн болон хувийн ашиг сонирхлоос хараат бус байдал бол олон нийтийн үйлчилгээний мэдээллийн хэрэгсэл оршин тогтнох суурь тулгуур юм.

Ерөнхийдөө, олон нийтийн радио телевизийн үйлчилгээний утга нь өөр өөр үүрэг даалгавар, санхүүгийн эх сурвалж, эзэмшигчид г.м бүгдийг “олон нийтийн ашиг сонирхлын” үүднээс авч үзэх радио телевизийн талаархи цогц ойлголт гэж үздэг байсан “классик” (Английн) ойлголтоосоо өөрчлөгдсөн. Өнөөдөр олон нийтийн радио телевизийн үйлчилгээг арилжааны, хувийн хэвшлийн сектороос ялгаатай хэвлэл мэдээллийн хэрэгслийн нэг өвөрмөц сектор гэж үздэг болсон.

2.2. Эдийн засгийн дэмжлэг

Олон улсын зөвлөгөөнөөр шууд, сонгомол татаасаас илүүтэй *шууд бус, ерөнхий* татаас олгохыг дэмждэг. Үүний цаадах шалтгаан маш энгийн: шууд, сонгомол татаасыг ихэвчлэн улс төрийн болон бусад төрлийн оролдлого, арга заль гэж үзэх нь бий.

Ерөнхий татаасын хандлага гэдэг нь ерөнхийдөө мөнгөний дийлэнх хувийг зах зээл дээр хүчирхэг хэсэгт өгч, ингэснээр олон ургалч үзэлын зорилгод сөрөг үр дагавар учруулах гэсэн утгатай.

2.3. Шууд бус дэмжлэг

Хэвлэл мэдээллийн хэрэгслийн секторт олгох шууд бус төрийн санхүүгийн тэтгэлэг нь хэвлэл мэдээллийн компаниуд болон бүтээл гэсэн ангилалд ч өгдөг ерөнхий шинж чанартай зүйл юм. Европын ихэнх улс орнууд олон нийтийн хэвлэл мэдээллийн секторт

ном, өдөр тутмын сонины НӨАТ-ыг хөнгөлөх зэргээр зарим төрлийн татварын хөнгөлөлт үзүүлдэг. Франц улсад сэтгүүлчдэд татварын хөнгөлөлт үзүүлдэг. Шуудангийн болон харилцаа холбооны тарифыг төрөөс хянадаг улс орнуудад (Бельги, Швейцарь) холбогдох татварын хөнгөлөлт байдаг.

Швед улсад өдөр тутмын сонинууд хоорондын хамтын ажиллагаанд төрийн санхүүгийн тэтгэлэг олгох замаар дэмжлэг үзүүлэх анхны системийг нэвтрүүлэх санал саяхан гаргажээ. Өнгөц харахад ийм төрлийн дэмжлэг нь өрсөлдөөний зарим элементийг үгүй хийх зорилготой байдаг учраас олон ургалч үзэлаас зөрж буй мэт харагдана. Гэхдээ гол санаа нь үйл ажиллагааны бүх салбарт хамтын ажиллагааг бий болгох явдал юм. Мэдээж хэрэг зар сурталчилгаа, түгээлт буюу эдийн засгийн бусад талын өрсөлдөөнөөр хэвлэл мэдээллийн хэрэгслийг бизнесээс шахаж болно. Ийм учраас олон ургалч үзэлд өрсөлдөөн хор хөнөөлтэй мэт харагдаж болно. Швед улсад сонинуудад үзүүлэх төрийн санхүүгийн тэтгэлэг нь мэдээлэл түгээлтийн хувьд өрсөлдөж буй сонинуудын хамтын ажиллагааны урьдач нөхцлийг шаарддаг. Ийнхүү хамтын ажиллагаанаас дүнгээс хамаарч АНУ-ын хууль тогтоомжоор хэвлэлийн компаниудад өрсөлдөөний тухай хуулиас чөлөөлөгдөх боломж олгодог байна.

2.4. Ил тод байдал

Ил тод байдлыг зарим тохиолдолд хэвлэл мэдээллийн хэрэгсэлд олон ургалч үзэлыг бий болгох зорилгод хүрэх зорилт, зарим тохиолдолд түүнд хэрэглэгдэх арга зам гэж үздэг.

Өрсөлдөгчдөд дамжуулах ёсгүй мэдээлэл дээр тодорхой хэмжээгээр эрх мэдэл оршдог учраас ил тод байдал зарим талаар эрх мэдэл, удирдлагын тухай ойлголттой холбогдоно. Бүрэн ил тод байна гэдэг нь нийгмийн аль ч хүрээнд хүн бүхний хувьд эрх мэдэл багатай байна гэсэн үг юм.

Хэвлэл мэдээллийн хэрэгслийн эзэмшилийн тухай захирамж гаргах төслийн бэлтгэл ажлын хүрээнд Европын комиссоос гаргасан тайланд ил тод байдал ба хяналт удирдлагын холбоо хамаарлын тухай судалсан байна. Тус судалгааны үр дүн нь зөвхөн хэвлэл мэдээллийн хэрэгслийн албан ёсны эзэмшилээр зогсохгүй эрх мэдлийн бусад талыг харгалзан үзсэн хэвлэл мэдээллийн компаниудын хяналт удирдлагад хандах ерөнхий хандлага юм. Ийм учраас хэвлэл мэдээллийн хэрэгслийн ил тод байдлын хяналтанд гэрээ хэлцэл, санхүүгийн хараат байдал гэх мэт нөлөөллийн хүчин зүйлүүдийн хамрах хүрээг багтаах нь зүйтэй.

“Төгс” зах зээлийн эдийн засгийн үүднээс үзвэл ил тод байдал буюу бүрэн мэдлэг нь мэдээлэл өгч буй нийлүүлэгчтэй холбоотой хэрэглэгчийн эрх мэдлийг нэмэгдүүлдэг: хэрэглэгчид ханган нийлүүлэгчдийн санал болгож буй зүйлийг яг таг мэдсэн нөхцөлд л хамгийн сайн буюу хамгийн “оновчтой” сонголтыг хийдэг.

Яагаад ил тод байх ёстой вэ? Ерөнхийдөө энэ асуултын хариулт нь: хэрэглэгч буюу олон нийтийн мэдээллийн хэрэгслийн хэрэглэгч нь хамгийн их мэдээлэл бүхий сонголтыг хийхийн тулд бүтээгдэхүүний тухай, мөн түүнийг үйлдвэрлэгч, ханган нийлүүлэгчийн ерөнхий мэдээлэл, ашиг сонирхол зэргийн талаар аль болох их зүйл мэдэх хүсэлтэй байдаг. Гэтэл энд илүү улс төрийн шинжтэй зарим шалтгаанууд бий. Тэдгээрийг дараах байдлаар ангилж болно:

Зохицуулалтын үндэс :

Зарим тохиолдолд хэвлэл мэдээллийн хэрэгслийн зах зээлд тодорхой хэмжээгээр хөндлөнгөөс оролцох шаардлагад анхаарал хандуулбал олон нийтийн ашиг сонирхол нь бодит байдал дээр эрх мэдлийн үнэлгээтэй холбоотой байх ёстой. Жишээлбэл, чухамдаа хэн удирдаж байгааг нь мэдэлгүйгээр компаний эсвэл бүлэг компаниудын үйл ажиллагааг зохицуулах буюу хөндлөнгөөс оролцох нь утгагүй юм.

Ардчилсан нийгэмд эрх мэдлийг хэрэгжүүлэхтэй холбоотой олон нийтийн мэдээллийн ерөнхий нөхцөл шаардлага нь:

Орчин үеийн ихэнх ардчилсан оронд хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь эрх мэдлийг хэрэгжүүлэх, түүний төлөө тэмцэх арга хэрэглүүр болдог учраас олон нийтэд тэдэнд өөрсдөд нь нөлөө үзүүлдэг хэвлэл мэдээллийн хэрэгсэлд зайлшгүй байх ёстой наад захын суурь ашиг сонирхол бүхий мэдээлэл өгдөр байх наад захын стандарттай байх ёстой.

Ил тод байдлыг дээшлүүлэх арга замууд: Хэвлэл мэдээллийн сектор хөндлөнгийн оролцооны буюу сайн дурын (ж нь статистикийн гэрээ хэлцэл, үзэгчдийн хувь хэмжээний тухай бусад мэдээлэл) болон хуулиар тогтоосон аргууд байдаг. Эдгээр аргуудын аль алинд нь илүү “идэвхгүй-хориглосон” эсвэл илүү идэвхтэй-судалгааны хандлагаар хандвал зохино. Мөн аль ч арга нь илүү ерөнхий бөгөөд бүх бизнес, байгууллагад тохирдог эсвэл илүү нарийн бөгөөд зөвхөн хэвлэл мэдээллийн секторд тохирдог байж болно.

Хэвлэл мэдээллийн хэрэгслийн сектор дахь ил тод байдлын талаар Европын Зөвлөлийн гаргасан (1994) санал зөвлөмжинд боломжит аргын хувьд ил тод байдлын хүрээг тодорхойлжээ. Гэхдээ ерөнхийдөө ил тод байдлын хэмжээ, хүрээ нь тухайн улс орны удирдлагын улс төрийн идэвх чармайлтаас нэлээд шалтгаалдаг.

Ил тод байдлын тухай хуулиар тогтоосон ерөнхий зохицуулалт: Ихэнх улс оронд компаниудын эзэмшлийг тодорхой хэмжээгээр ил болгох шаардлага тавьдаг. Зарим улс орон энэ ил тод байдлыг зөвхөн хөрөнгийн биржид бүртгэлтэй компаниас шаарддаг, харин зарим нь бүх компаниудад илүүтэй ерөнхий хандлагаар хандах нь ч бий. Ил тод байдал нь олон нийтийн удирдлага захиргааны эсвэл олон нийтийн ерөнхий хэрэгцээтэй холбогдож болно. Хэвлэл мэдээллийн компаниуд дүрмийн дагуу энэхүү ерөнхий зохицуулалтанд хамрагддаг.

Хэвлэл мэдээллийн хэрэгслийн онцгой дүрэм журам: Сонины салбарынхан эзэмшигч, редактор, гүйцэтгэх захиралынхаа нэрийг хэвлэн гаргах ёстой гэх мэт олон тусгай дүрэм журмыг Европын хэвлэл мэдээллийн компаниуд дагаж мөрддөг. Олон улс орон компанийн нэрийг сонинд гаргасан байхыг зайлшгүй шаардлага болгодог ч ингэснээр

жинхэнэ ил тод байдлыг бий болгож чаддаг эсэх нь эргэлзээтэй. Олон тохиолдолд компаний нэр нь тухайн бүтээгдэхүүний цаадах жинхэнэ ашиг сонирхлын тухай ихийг илэрхийлж чадахгүй бөгөөд тийм мэдлэгийг олж авахад нэлээд их хүчин чармайлт гаргах шаардлагатай болж мэднэ. Зарим улс орон борлуулалтын эсвэл тухайн хэвлэл мэдээллийн бүтээгдэхүүний хүртээмжийн тухай мэдээллийг бүтээгдэхүүндээ багтаасан байх шаардлага тавьдаг.

Нэг онцгой тохиолдол бол радио, телевизийн *тусгай зөвшөөрөл*, тусгай зөвшөөрөл олгох явдал юм. Ерөнхийдөө засгийн газар буюу түүний харьяа агентлаг тийм шийдвэр гаргах асуудлыг хариуцдаг. Энэ тохиолдолд ил тод байдлыг бий болгох нь тусгай зөвшөөрөлгүй байх нөхцлийг дэмждэг чөлөөт зах зээлийн нөхцөл байдлаас илүү хялбар байдаг. Европын ихэнх улс орнууд радио, телевизүүдэд тэдний түгээлтийн төрлөөс үл хамааран тусгай зөвшөөрөлийн систем хэрэгжүүлдэг.

Тусгай зөвшөөрөл дээр суурилсан бүтэц зохион байгуулалтанд олон янзын хүндрэл бэрхшээл тулгарч болно. Жишээ татвал, тусгай зөвшөөрөлгүй эзэмшигчээр удирдуулсан групп компанитай гэрээгээр эсвэл эдийн засгийн хараат байдлаар холбогдсон компани байж болно (жишээ болгон Словяны “Поп ТВ”-г дурдаж болно). Эцэстээ хуулийн дагуу гарч ирж буй зөвшөөрөл, тусгай зөвшөөрөлийн нөхцлийн аль аль нь Шведийн хэвлэл мэдээллийн группыг уг сувгийн эрхийг гартаа авахаас сэргийлж чадаагүй юм.

Дижитал аргаар (Интернет, газраас нэвтрүүлгээ дижиталаар эсвэл хиймэл дагуулаар цацах, бусад төрлийн сүлжээнүүд) түгээх шинэ хэлбэрүүд үүссэнээс шалтгаалан тусгай зөвшөөрлийн систем нь бүхэлдээ удаан оршин тогтнох боломжгүй байж магадгүй. Эдгээр хөгжил дэвшил нь бидний мэдэх “суваг” гэсэн ойлголтыг үгүй болгож ил тод байдлын нөхцлийг үндсээр нь өөрчилж мэднэ.

Ил тод байдлыг дээшлүүлэх “идэвхитэй” арга зам: Хэрэв ил тод байдал нь эрх мэдлийг үнэлэх, эрх мэдлийн бүтэц зохион байгуулалтанд нөлөөлөх арга хэрэгсэл юм бол сонирхогч талууд компаниудаас мэдээллээ ил болгохыг үүрэг болгосон албан ёсны дүрэм журман дээр найдаж болохгүй. Мэдээллийг идэвхтэй эрж хайх ёстой бөгөөд олон тооны арга замыг ашиглах ёстой. Судалгаа бол тийм нэг арга зам бөгөөд шинжлэх ухааны судалгаа болон мэдээлэл, баримт бичиг цуглуулах аргын аль аль нь болно. Ийм судалгаа шинжилгээний үр дүнд мэдээллийн бааз, бүртгэл, статистик, олон төрлийн хэвлэл нийтлэл, харьцуулалтын схем г.м зүйлс үүсдэг. Европын Холбоо удирдамж гаргах бэлтгэл ажлынхаа хүрээнд бүх гишүүн орон өөрийн хил доторх хэвлэл мэдээллийн хэрэгслийн эзэмшлийн асуудлыг **үнэлэх, хянах чадвартай** байх ёстой гэсэн урьдчилсан шаардлага гаргасныг дурдах нь зүйтэй.

Зохицуулалтын бус арга зам: Олон улс оронд тодорхой компаний ашиг сонирхол, эзэмшлийн асуудлыг редакцийн ажилтнууд мэддэг байх нөхцлийг баталгаажуулдаг редакцийн хууль тогтоомж байдаг.

Ил тод байдалд учрах бэрхшээлүүд: Бизнесийн орчны бүхий л секторт ил тод байдалтай холбоотой хүндрэл бэрхшээл гардаг. Жишээ нь:

- Компани дахь бизнесийн хамтрагчдын дотоод гэрээ хэлцлийн ерөнхий нууцлал: Эзэмшил нь компани дахь удирдлага хяналтын талаар тодорхой мэдээллийг өгдөг хэдий ч гэрээ хэлцэл нь эрх мэдэл, стратегийн шийдвэр гаргах үйл явцыг харуулдаг.
- Хэвлэл мэдээллийн компаниуд ихэвчлэн нэлээд түвэгтэй хамтын ажиллагаа, хамтрагчтай холбогдсон байдаг учраас компаний алагчлалгүй байдлыг зохих хэмжээнд барьж үр дүнтэйгээр удирдах аргыг шийдэх нь бэрхшээлтэй. Үүний нэгэн жишээг дурдвал тусгай зөвшөөрөл эзэмших дээд хязгаарын хэмжээг тодорхойлох үзэгчдийн хувь хэмжээг тооцохдоо телевизийн компаниуд дахь хамгийн бага хувьцааны тухай Германы хууль тогтоомж юм. Энэ бол Европын Холбооны удирдамжийг хэрэгжүүлэхэд учирч буй томоохон саадын нэг нь юм.
- Дээрхийн адил үзэгчдийн хувь хэмжээний талаарх статистик нь нэлээд ээдрээтэй, найдваргүй байдаг бөгөөд тийм мэдээлэл дээр үндэслэн гаргасан ил тод байдлын тухай дүрэм журам түүний нэгэн адил асуудалтай байх болно.

Тусгай зохицуулалт

Хэвлэл мэдээллийн хэрэгслийг зохицуулаад зогсохгүй энэ салбарт зориулсан онцгой хатуу чанд зохицуулалт хийдэг улс орнууд нь өрсөлдөөний зохицуулалтанд нэлээд өөрөөр ханддаг. Европын ихэнх орнууд радио телевизийн салбарт өрсөлдөөн ба/эсвэл олон ургалч үзлийг бий болгохын тулд эзэмшилд тодорхой хэмжээгээр хязгаарлалт хийх зохицуулагч алба байгуулсан байдаг. Эдгээр орнуудаас дурдвал: Бельги, Герман, Франц, Итали (телеком компаниудыг мөн хянах шинэ алба байгуулах явцдаа байгаа), Норвеги (мөн хэвлэл мэдээллийн хэрэгслийн олон ургалч үзлийн алба байгуулж байгаа), Португал (Alta Autoridade гэсэн байгууллагатай), Их Британи (хүчирхэг байгууллагуудтай). Зүүн болон Төв Европын ихэнх орнууд тусгай зөвшөөрөлийн хуваарилалтыг хариуцдаг радио, телевизийн “зөвлөл”-тэй байдаг.

Хэвлэл мэдээллийн зохицуулалтыг ихэвчлэн бусад олон нийтийн байгууллагаас хянадаг (Франц, Их Британий хувьд), харин бусад орнуудад (Норвеги, Итали) салбарын хэмжээний бодлого журам гаргасан байдаг.

Олон улсын зохицуулалт

Олон улсын байгууллагууд хянах үйл явцад нэлээд чухал үүрэг гүйцэтгэж ирсэн. Чухамдаа олон улсын арга хэмжээг ихэвчлэн энэ салбарын талаарх олон улсын зөвлөгөөн хэлэлцүүлгээс санаачлан гаргадаг. Дээр тайлбарласанчлан Европын Зөвлөл нь хүний эрхийн салбарт хүлээсэн үүргийнхээ дагуу хэвлэл мэдээллийн хэрэгсэл дэх монополист хандлагыг шалгах, үнэлж дүгнэх, түүнтэй тэмцэх арга хэмжээний тухай хэлэлцэх үүрэгтэй байдаг. Зохицуулалт, дүрэм журмыг хэрэгжүүлэх ерөнхий зорилтондоо өнөөдөр хүрээгүй байгаа хэдий ч энэ салбарт хяналтын байгууллагын үүрэг гүйцэтгэх хүсэлтэй байгаагаа монополизлолыг үнэлж дүгнэх, эсэргүүцэхийг дэмжих замаар маш тодорхой илэрхийлсэн юм.

Дээр дурдсанчлан АНУ, Их Британи улсыг тус байгууллагаас гарахад хүргэсэн 1970 болон 1980-аад оны үеийн хэвлэл мэдээллийн хэрэгслийн талаар улс төрийн маргааны үр дагаврын горьг амссаар байгаа хэдий ч ЮНЕСКО дэлхийн хэмжээнд хөгжлийг хянах арга хэмжээнүүд авсаар байна.

Европын Хэвлэл мэдээллийн Институт гэх мэт төрийн бус байгууллагууд болон их сургуулийн секторын олон байгууллагууд хяналтын сүлжээ болгон хөгжүүлж болох зүйлсэд мөн оролцсоор байна.

3. Конвергенцийн эрин үеийн чиг хандлага ба хөгжил

Юуны түрүүнд, хэдийнээ хүчирхэгжсэн төвлөрлийг улсаас зөвшөөрөх байдал нэмэгдэж байна: зарим улс оронд (Их Британи, Герман, Франц) зах зээлд эзлэх хувь хэмжээ ихэсч хэвлэл мэдээллийн хэрэгслийн томоохон оролцогчдын асуудалд анхаарал хандуулах нь ерөнхийдөө нэмэгдсэн. Үүнийг даган хэвлэл мэдээллийн хэрэгсэлд илүү их хэмжээний “дотоодын олон ургалч үзэл” байлгах хүсэлт гарч ирэх хандлагатай болж байна.

Хоёрт, хэвлэл мэдээллийн төвлөрлийг олон улсын хэмжээнд зохицуулахыг эсэргүүцэх хандлага нэмэгдсэн. Энэ төрлийн зохицуулалт (ялангуяа Европын холбоо) нь хэдийнээ монополь болсон хувь хүмүүсийн ашиг сонирхлын төлөө үйлчилж магадгүй гэж зарим нь маргадаг. Харин зарим нь Канцлер Кол Европын Хорооны ерөнхийлөгчид илгээсэн захидалдаа бичсэн шиг олон улсын зохицуулалт нь хэвлэл мэдээллийн амжилттай, ашигтай корпорацуудын жам ёсны хөгжил дэвшил, нэгдэлд саад болж Европын өрсөлдөх чадварт (АНУ, Японтой харьцуулахад) хор хохирол учруулна гэж мэтгэдэг.

4. Хил дамнасан телевизүүдийн тухай Европын гэрээ

Энэхүү гэрээ нь хил дамнасан үндэсний радио телевиз рүү чиглэдэг. Дээрхи шинж чанар нь анх нэгдсэн Гишүүн Улсууддаа хангалттай байдаг учраас бусад Гишүүн Улсуудад зориулагдаагүй юм. Дээр дурьдсан цар хүрээний дагуу энэхүү гэрээ нь бие даасан үндэсний радио телевизийн шинж чанарыг зохицуулахгүй.

Хил дамнасан телевизүүдийн тухай Европыг Гэрээний 6-р зүйлд ямар ч нэвтрүүлэгч нь хүсэлтээрээ дор хаяж “нэр болон нэрийдэл, нэвтрүүлэгчийн албан тушаал болон байр суурь, албан ёсны төлөөлөгчдийн нэрс, хөрөнгийн бүрэлдэхүүн, шинж чанар, хөтөлбөрийн үйлчилгээнд зарцуулах санхүүжилтийн зорилго болон хэлбэр зэрэг нэвтрүүлэгчид шаардлагатай болон шаардагдах” зүйлсийн талаар тодорхой хэмжээний мэдээлэлтэй байхыг шаарддаг. Хэдийгээр энэхүү зүйлд нэвтрүүлэгч нь эдгээр мэдээллийг хэвлэн нийтлэхийг шаарддаггүй боловч ямар нэгэн албаны болон хувь хүний хүсэлтийн дагуу эрх мэдэл бүхий албан тушаалтан эдгээр мэдээллийг мэдэх боломжтой байхаар хийхийг шаарддаг. Тайлбар санамж бичигт заасны дагуу 6-р зүйлийн 13 нь нэвтрүүлэгчийн жинхэнэ нэр болон олон нийтэд танигдсан нэр, радио телевизийн байгууллагын бүтэц, түүний албан ёсны байр суурь болон санхүүжилтийн хэлбэрийг мэдэх гэсэн олон нийтийн сонирхолыг хангахад чиглэгдсэн байдаг.

Энэхүү гэрээний хянан засварласан гэрээний “Мэдээллийн хэрэгцээ түүний ил тод байдал” гэсэн 5-р зүйлийн дагуу, хэвлэл мэдээллийн хэрэгслийн үйлчилгээ үзүүлэгч нь нэвтрүүлэгчийн байр суурь, албаны төлөөлөгчдийн нэрс, хөрөнгө болон эд зүйлсийн бүтэц болон хөтөлбөрийн үйлчилгээний санхүүжилтийн зорилго болон хэлбэрийн талаар

мэдээллээр хангах шаардлагагүй. Мөн өмнөх зүйл дээр “хэвлэл мэдээллийн хэрэгслийн олон ургалч үзэл ба түүний агуулгын онцлог” гэсэн гарчиг бүхий шинэ 12-р зүйлийг хянан засварлаж оруулсан байна. Энэхүү 12-р зүйл нь 2 хэсгээс тогтох бөгөөд эхнийх нь “Талууд хэвлэл мэдээллийн хэрэгслийн үйлчилгээ үзүүлэгчийн өмчлөх эрхийн илэрхий ил тод байдлыг дэмжинэ ” гэсэн байдаг. Өөрөөр хэлбэл, энэхүү шинэ заалт нь талуудад зүгээр нэг ил тод байдлыг биш илэрхий бүрэн ил тод байдлыг дэмжих үүрэг ноогдуулж байгаа гэсэн үг юм. Нөгөө хэсэг нь өмнө нь байсан 6-р зүйлээс илүү хязгаарлагдмал болсон бөгөөд энд талуудыг тодорхой хэмжээний ил тод байдлыг дэмжихийг шаардсан харин үүнд яг хүрэхийг шаардаагүй. Харин өмнө нь хэрэгжиж байсан 6-р зүйлд хэрэглэж буй мэдээллээс гол асуудлыг олж авдаг эрх мэдэл бүхий албан хаагчдад мэдээллийг тодорхой байхаар тусгайлан бэлдэхийг шаарддаг байсан бол энэ шинэ заалтанд мэдээлэл бодитой байгааг хэрхэн батлахыг тогтоох тал дээр гишүүн улсуудыг чөлөөтэй чигээр нь үлдээсэн.

5. Европын Холбооны хэвлэл мэдээллийн салбар дахь ил тод байдлын талаархи холбогдох арга хэмжээнүүд

Европын Холбооны хүрээнд дараах 2 ойлголт байна. Үүнд: хэвлэл мэдээллийн хэрэгслийн эзэмших эрхийг ил тод байлгах талаархи заавал дагаж мөрдөх ёсгүй зөвлөмжүүд болон дуу дүрс бичлэгийн салбарт хамгийн багадаа ямар ил тод байдал шаардлагатай вэ гэдгийг тогтоосон заавал дагаж мөрдөх дүрэм журам орно. Европын Холбооны дүрэм журамд нийцдэггүй радио телевиз, хэвлэл, сонин сэтгүүл болон онлайн үйлчилгээ хоорондоо ялгаатай юм.

2008 оны 9 сарын 25-нд гаргасан Европын Парламентын тогтоол

Энэхүү Европын Парламентын заавал дагаж мөрдөх ёсгүй тогтоол нь хэвлэл мэдээллийн хэрэгслийн олон ургалч үзэл рүү чиглэсэн бөгөөд ялангуяа 35-р хэсэгт нэвтрүүлэгч болон нийтлэгчийн зорилго болон үндэслэлийг илүү ил тод байлгахад туслах үүднээс хэвлэл мэдээллийн хэрэгслийн эзэмших эрхийг тодруулж өгөх талаар байдаг. Энд Европын Холбооны хэд хэдэн түвшинд хэвлэл мэдээллийг ил тод байлгах ашиг сонирхлын талаар тусгадаг.

Удирдамж 2007/65/ЕС17

Эрх зүйн хувьд заавал дагаж мөрдөх дүрэм байх бөгөөд 3-р зүйлийн а-д “ямар ч дуу дүрс бичлэгийн хэвлэл мэдээллийн хэрэгслийн үйлчилгээ үзүүлэгч нь уг дүрмийн дагуу дараах мэдээллийг үйлчилгээ хүлээн авагчид хялбар, шууд болон байнга байхаар хүргэж байх ёстой” гэсэн байдаг.

Эдгээр мэдээлэлд:

- (a) Хэвлэл мэдээллийн хэрэгслийн үйлчилгээ үзүүлэгчийн нэр
- (b) Хэвлэл мэдээллийн хэрэгслийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагаагаа явуулах газар зүйн байрлал болон хаяг
- (c) Хэвлэл мэдээллийн хэрэгслийн үйлчилгээ үзүүлэгчийн хувийн мэдээлэл. Үүнд түүнтэй шууд болон холбогдож болохуйц түүний цахим хаяг болон вэбсайт багтана.
- (d) эрх бүхий захиргааны болон хяналтын байгууллагуудын зөвшөөрөл орно.

Хэдийгээр дээр дурьдсан мэдээллийг авах боломжтой боловч толгой компани, түүний эзэмшигч, санхүүжилт болон ихэнхи хувьцаа эзэмшигчийн талаархи мэдээллийг мэдэх боломжгүй байвал энэ нь олон нийтэд ил тод байдлыг бий болгодог эдгээр наад захын шаардлага нь үр дүнгүй байна гэсэн үг юм.

Хачирхалтай нь энэ зүйл нь ил тод байдлын дүрэм журмыг нилээн түвэгтэй болгоод байгаа юм. Радио телевизийн үйл ажиллагааг зохицуулах болон эдгээр тогтоолд нэвтрүүлэгчийг нийцүүлэх талаархи өөрийн гэсэн дүрэм журамтай Гишүүн улсууд болон бусад Гишүүн улсууд нь тодорхой хэмжээний хяналт тавьдаг. Үүнд: ил тод байдалтай хамааралтай хатуу чанга дүрэм журам хэрэгжүүлэх орно. Энэхүү заалт нь удирдамж 18-т тусгагдсан бүхий л салбарууд, Удирдамжийн зарим хэсэгт дурьдагдсан ил тод байдал руу чиглэгдсэн боловч Гишүүн улсууд бусад гишүүн улсуудаас үүсэлтэй ил тод байдлын талаархи чанга хатуу дүрэм журмыг хэрэгжүүлэхгүй байж болно.

Удирдамж 2000/31/ЕС19

Энэхүү электрон худалдааны удирдамж нь “мэдээлэл өгөх үйлчилгээний нийгэмлэг”-н тогтоосон “электрон аргаар мэдээлэл, үйлчилгээ хүлээн авагчийн хувийн хүсэлтээр ч бай ямар ч үйлчилгээнд төлбөр төлөх ёстой” хэмээх заалттай дүйцдэг. Сонирхолтой нь, ихэнхи онлайн сонингууд нь Электрон худалдааны удирдамж –д захирагддаг. Харин дуу, дүрс бичлэгийн хэвлэл мэдээллийн хэрэгслийн үйлчилгээг зохицуулдаг шиг тэдэнд ил тод байдлын шаардлагыг тавих юм бол онлайн бус сонигууд нь ямар ч хяналтгүй үлдэх болно. Үүнээс үзэхэд эдгээр одоо хэрэгжиж байгаа дүрэм журам нь цар хүрээнийхээ хувьд хязгаартай байна.

Өрсөлдөөн болон хамтарсан ил тод байдлын талаархи Европын Холбооны дүрэм журмууд

Хэдийгээр Европын Холбоо шударга өрсөлдөөн болон хэвлэл мэдээллийн хэрэгслийн компаниудын нэгдэлд хяналт тавих талаар дүрэм журам баталсан боловч эдгээр дүрэм журам нь хэвлэл мэдээллийн хэрэгслийн эзэмших эрхийн талаар бүрэн бөгөөд ойлгомжтой мэдээллийг өгч чадахгүй байна. Эдгээр Европын Холбооны дүрэм журам нь тодорхой компаниудыг тэдний хувьцаа эзэмших эрхийг олон нийтэд өгөхийг шаарддаг учраас нилээн чухал юм.

Хамтарсан ил тод байдлын шаардлагууд

Бүхий л европын компаниудын мэдээлэл өгөх нэг цэгийн үйлчилгээ нь цаг болоод зардал хэмнэдэг (р. 4). Эдгээр төвлөрөлт нь мөн хэвлэл мэдээллийн хэрэгслийн хам хүрээнд хамаарагддаг. Ийм учраас зарим хэвлэл мэдээллийн байгууллагууд нь хувийн компаниуд, хариуцлагатай байдал, түншлэл гэх мэт олон нийтийн аюулгүй байдлын асуудал болон тэдний зах зээлийн асуудлын талаархи Ил тод байдлын удирдамж дахь шаардлагуудыг хэрэгжүүлнэ. Магадгүй ихэнхидээ тулгардаг асуудал бол жагсаалтанд орсон хувьцаа эзэмшигч нараас шалтгаалан компаниудын сүлжээнд эзэмших эрхийг олгохгүй байх явдал юм.

Эхний алхмыг хийх нь үнэхээр үр дүнтэй боловч эцсийн эцэст хэвэл мэдээллийн хэрэгслийн ил тод байдлын салбарт энэхүү удирдамж нь хязгаартай хэрэгждэг.

Хорооны удирдамж 2007/14/ЕС 25

Энэхүү удирдамжид Европын Холбооны дүрэм журмын дагуу олон нийтэд тодорхой мэдээллийн талаархи үнэн зөв тодруулгыг хийж ил тод байхыг шаарддаг. Дор хаяж дараахь хэрэгцээг тодруулах шаардлагаатай. Үүнд: санхүүгийн тайлан, санал өгөх эрхийн ихэнхи хувьцааны талаархи мэдээлэл, зах зээлийн дайралтын удирдамжид нийцүүлэн мэдээллийг ил тод гаргах орно. Дээр дурьдсанчлан энэхүү удирдамж нь

тодорхой зах зээлийг ашиглан олон нийтийн аюулгүй байдлыг алдагдуулахгүй байх ёстой гэсэн удирдамжид тодорхойлсноор зөвхөн тодорхой зах зээл дэх олон нийтийн аюулгүй байдалд анхаарлаа хандуулдаг компаниуд руу чиглэдэг. Нэмж хэлбэл, ерөнхийдөө хэвлэл мэдээллийн байгууллагууд нь олон нийтийн аюулгүй байдалд анхаарлаа хандуулдаггүй. Хувьцаа эзэмшигчидийн талаарх мэдээлэлийг хэвлэл мэдээллийн байгууллагад хяналт тавьдаг хүмүүс илрүүлж чаддаггүй. Харин жирийн иргэдийн хувьд тодорхой байгаа мэдээллийг тайлах, илрүүлэх гэдэг нь маш хүнд хэцүү байдаг. Хэдийгээр энэ удирдамж эргэлзээгүй хэрэгтэй ашигтай арга хэрэглэгдэхүүн, мөн Европын холбоо хууль ёсны дагуу хэвлэл мэдээллийн хэрэгслийн ил тод байдлыг бий болгож байгааг харуулж чаддаг боловч хэвлэл мэдээллийн хэрэгслийн ил тод байдлын талаархи асуудлуудад оновчтой хариу өгч чаддаггүй.

Дотоодын зах зээлийн асуудал

а) Нууцыг хадгалахыг хүссэн эзэмших эрхийн талаархи мэдээлэл болон компанид тавих шаарлага нь хаана компани байгуулах болон түүний охин компанийг бас байгуулахад ч нөлөөлдөг.

б) Хэрвээ Гишүүн улсуудад түүний газар нутаг дээр идэвхитэй үйл ажиллагаа явуулж буй хэвлэл мэдээллийн хэрэгслийг ажиллуулах хэрэгтэй гэж үзвэл Гишүүн улсуудад компаниа байгуулахад нэмэлт төлбөр ноогдуулах болно. Энэ нь хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй холбоотой бараа болон үйчилгээний чөлөөт үйл явцыг бий болгоход саад болдог.

6. Дүгнэлт

Дээр дурдсан судалгаанууд нь биднийг Европын Холбооны үйл ажиллагаа нь хэвлэл мэдээллийн хэрэгслийн ил тод байдал, Дотоодын зах зээлийг дэмжихэд оршдог гэсэн дүнэлт гаргахад хүргэж байна.

Европын холбоо нь тусгай хэвлэл мэдээллийн салбар болох сонин сэтгүүл болон санаачлага гаргах нь зарчмын хувьд боломжтой болох нь тогтогдсон хамтын ашиг сонирхлын хүрээнд ил тод байдлыг бий болгох үйл ажиллагаагаа аль хэдийн хэрэгжүүлээд эхэлсэн. Энэ салбарт хамтран ажиллах Европын холбооны үйл ажиллааны хэрэгцээг тогтоох энэ мэт арга замуудыг Гишүүн улсууд хэрэгжүүлэх тал дээр харьцангуй баригдмал байгаа юм.

Ялангуяа, хэвлэл мэдээллийн хэрэгслийн компаниудын тодорхой хэмжээний хувьцааг эзэмшигчидтэй холбоотой болон компаний үйл ажиллагаанд нөлөөлдөг хувь хүн болон байгууллагуудын талаархи мэдээллийг нээлттэй болгох нь чухал юм гэж үздэг. Төвлөрөл нь энэ мэдээллийг хэнд хаана хэвлэл мэдээллийн хэрэгслээр жишээ нь жил бүрийн тайлан баланс юм уу бие даасан хэвлэл мэдээллийн хэрэгслийн зохицуулагчаар эсвэл энгийн бизнес бүртгэлийн тусгай салбараар гэх мэт замаар ил тод болгох вэ гэдгээ мэддэг байх хэрэгтэй.

Уламжлалт хандлагаар бол радио болон телевиз нь хоёулаа энэхүү дүрэм журмын зохицуулах зүйл болох билээ. Радио телевизийн нөлөөг хэвлэлтэй болон хязгаарлагдмал хэмжээ бүхий нэтрүүлэгүүдтэй харьцуулан радио телевизтэй холбоотой дүрэм журмыг хэргэжүүлдэг. Радио телевизийн үйлчилгээтэй холбоотой ил тод байдал нь тусгай зөвшөөрөл авсан нөхцөл байдал болоод санхүүжилт болон эзэмших эрхийг шаарддаг тусгай зөвшөөрөлийн системийн дагуу хэрэгжиж байгаа бөгөөд үүнд хэвлэл багтдаггүй. Энэхүү төвлөрөл бутрах задрахаас сэргийлж хэвлэл болон дуу дүрс бичлэг багтдаг хэвлэл мэдээллийн хэрэгслийн талаархи дүрэм журмыг хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзэж байна.

“Дижитал эрин дэх олон нийтийн радио телевиз: хоёрдмол системийн ирээдүй” гэсэн саяханы мэдэгдэлд Соёл болон боловсролын Парламентын хороо нь “Бүх Гишүүн Улсуудад хувийн нэвтрүүлэгчийн эзэмших эрхийн ил тод байдал нь хамгаалагдахгүй” хэмээн тэмдэглэсэн бөгөөд Европын хороог энэ бүх үйл ажиллагааг дэмжиж хянаж ажиллахыг шаардсан.”

Төвлөрөлтийн өөр арга зам бол Үндсэн эрхийн мөрийн хөтөлбөр юм. Энэ нь нийгмийн бүхий л давхаргын байгууллагуудтай мэдээлэл солилцох, хамтран ажиллах нөхцөлийг бүрдүүлдэг гол суваг юм. Энэхүү мөрийн хөтөлбөр нь өргөн цар хүрээ бүхий гишүүнчлэлтэй бөгөөд үүнд Улаан загалмай гэх мэт үндэстний болон олон улсын байгууллагууд ордог. Тэд мөн сүүлийн 5-н жилийн төлөвлөгөөний хүрээнд “Холбооны иргэдийн оролцоо болон Холбооны ардчилсан үйл ажиллагаа”-г хөнгөвчлөхийн тулд хэвлэл мэдээллийн ил тод байдлыг бий болгох судалгаанд анхаарлаа хандуулж байна. Гишүүнчлэл нь нээлттэй бөгөөд харин 2010 оны гишүүнчлэл одоогоор хаагдсан байгаа юм. Энэхүү хөтөлбөрийн гишүүн болохын тулд ардчилсан нийгэмд хэвлэл мэдээллийн хэрэгслийн үйл ажиллагаа руу чиглэсэн байгууллагуудад элсэн орох боломжтой юм.

Хэвлэл мэдээллийн хэрэгслийн төвлөрөлт гэдэгт цөөн тооны конгломерат болон корпораци тэнцүү хувиар зонхилох хэвлэл мэдээллийн хэрэгслийн худалдаалах эрхийн ихэнхийг эзэмшдэг гэсэн ойлголт хамаарагддаг. Энэ ч утгаараа, хэвлэл мэдээллийн хэрэгслийн нэгдэл гэсэн нэр томъёог голдуу социологийн үүднээс хөнөөлтэй, аюултай болон асуудалтай гэсэн ойлголттой дүйцүүлэн хэрэглэдэг. Энэ нэр томъёо нь дээрхи хэвлэл мэдээллийн хэрэгслийн байгууллага дахь олигополь болон монополийг тодорхойлдог эсвэл цөөн тооны олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, үндэстний хэвлэл мэдээллийн хэрэгсэл, болон хэвлэл мэдээллийн хэрэгслийн когломератын тэнцүү тооны ач холбогдолыг тодорхойлдог. Хэвлэл мэдээллийн хэрэгслийн төвлөрөл бол олон нийтийн, бүс нутгийн болон тодорхой үндэстний асуудал байсаар байна.

Дөрөв. ГАДААД УЛС ОРНУУДЫН ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧНЫ ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

Дараахь улсуудын хууль, эрх зүйн орчны судалгааг ил тод байдал болон эзэмшил, төвлөрлийн асуудлаархи ижил асуудлыг гарган, тухайн асуудлаар хуульчилсан, тогтоосон заалтууд хэрхэн тусгагдсан талаархи судалгааг авч үзлээ.

Нэг. Франц улс

Хэвлэл мэдээллийн компанийн эзэд/хувьцаа эзэмшигчдийг нэрлэхэд тавигддаг шаардлагууд

Франц улсын 1984 оны Ил тод байдлын тухай хуулинд (*Хууль №. 84-937*) заасны дагуу хамтын хөрөнгө оруулалттай бүх компани нь гаргасан хувьцаагаа олон нийтэд нэрлэсэн байх шаардлагатай (хувьцаа эзэмшигчдийг нэрлэсэн байх ёстой).

1986 оны Харилцаа холбооны эрх чөлөөний тухай хуулийн (*Хууль №. 86-1067*) 36-р зүйлд зааснаар бүх хэвлэл мэдээллийн компани, байгууллагууд гаргасан хувьцаагаа мөн нэрлэсэн байх ёстой ажээ. 75, 76-р зүйлд зааснаар 36-р зүйлээс ямар нэг байдлаар

зайлсхийсэн тохиолдолд хувь хүмүүст 6,000-аас 120,000 франк, хязгаарлагдмал хариуцлагатай компанийн удирдлагад 10,000-40,000 франкийн торгууль ногдуулах аж.

Хууль №. 86-1067-гийн 37-р зүйлд зааснаар хэвлэл мэдээллийн компаний тухай дараах мэдээллийг олон нийтэд ил болгосон байх ёстой:

- Хэрэв тухайн компанийг хувь хүн эзэмшдэг бол эзэмшигч(ид), хамтран эзэмшигч(ид)-ийн овог нэр(үүд)
- Хэрэв тухайн компани нь хуулийн этгээд бол компаний нэр, байршил, эрх зүйн баримт, эрх бүхий төлөөлөгчид болон гурван гол ажилтны нэр
- Бүх тохиолдолд хэвлэл нийтлэлийн хянан тохиолдуулах ажлыг хариуцсан хүмүүсийн нэр
- Хянан тохиолдуулсан хэвлэл нийтлэлийн жагсаалт болон тухайн компаний оролцдог хэвлэл мэдээллийн бусад (дүрс, дуу бичлэгийн) үйл ажиллагааны жагсаалт

Компаний данс тайланг ил болгох шаардлагууд: Эдийн засгийн ерөнхий хуулийн зарчмын дагуу Францын бүх компаниуд данс тайлангаа Худалдааны Шүүхийн Бүртгэлийн газарт гаргах шаардлагатай.

Хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийн орлогын эх үүсвэрийг ил болгох шаардлагууд: Дуу, дүрс бичлэгийн мэдээлэл дамжуулах тусгай зөвшөөрөл авахаар өргөдөл гаргахдаа компаниуд өөрийн хэвлэл мэдээллийн ашиг орлогыг Conseil Supérieur de l'Audiovisuel-д мэдээлэх ёстой. Хэвлэл мэдээллийн ашиг орлого нь мөн Худалдааны шүүхэд компанийн данс тайлангаа бүртгүүлэх замаар ил болсон байдаг.

Хувьцаа, хөрөнгө болон хувьцаа эзэмшилд гарсан өөрчлөлтийг эрх бүхий Зохицуулах хороо, албанд мэдэгдэх шаардлагууд: 1994 оны Радио, телевизийн тухай хууль № 94-88-д зааснаар хувь хүн эсвэл хуулийн этгээд нь радио, телевизийн компаний хувьцаа нь хөрөнгийнх нь эсвэл сонгох эрхийн 20%-д хүрсэн тохиолдолд тухайн 1 сарын дотор энэ тухайгаа Conseil Supérieur de l'Audiovisuel-д мэдэгдэх ёстой. Анхны тусгай зөвшөөрөл олгох үед байсан хөрөнгө, хувьцаа, удирдах зөвлөлийн гишүүд болон санхүүгийн удирдлагад нь томоохон өөрчлөлт гарсан тохиолдолд радио телевизийн үйлчилгээний тусгай зөвшөөрлийг Conseil Supérieur de l'Audiovisuel буцаан хурааж болдог байна.

Эзэмшил ба менежментийн тухай хууль тогтоомж: тусгай зөвшөөрөл олгоход тавигдах шаардлагууд, ерөнхий зөвлөл дэх нийгмийн бүлгүүдийн төлөөлөл: Радио телевизийн компаниудын хэвлэл мэдээллийн эзэмшилийг одоогоор хэд хэдэн дүрэм журмаар зохицуулдаг. 1994 оны Радио телевизийн тухай Хууль № 94-88-д зааснаар хувь хүн, хуулийн этгээд нь телевизийн үйлчилгээ явуулах зөвшөөрөлтэй радио телевизийн компанийн сонгох эрхийн 49%-ийг эзэмших хязгаартай байдаг (өмнө нь 1986 оны Хууль № 86-1067-д зааснаар энэхүү хязгаар нь 25% байжээ). Үндэсний радио телевизийн тусгай зөвшөөрөлтэй хоёр дахь компанийн сонгох эрх болон хөрөнгийн 15%-ыг, гурав дахь компанийн 5%-ыг эзэмшиж болно гэж тогтоосон байдаг.

Улсын хэмжээнд нэвтрүүлгээ цацдаг үндэсний телевизийн сувагт зориулж нэг компанид зөвхөн нэг тусгай зөвшөөрлийг олгох боломжтой. Нэг компанийн үйлчилгээ нь мөн нэг хиймэл дагуулын тусгай зөвшөөрлөөр хязгаарлагддаг. Газраас болон хиймэл дагуулаар нэгэн зэрэг нэвтрүүлгээ цацдаг телевизийн үйлчилгээг нэг үйлчилгээ гэж

тооцдог ба зөвхөн газраас цацах 1 зөвшөөрөл шаардлагатай байдаг. Бүс нутгийн болон орон нутгийн телевизийн эрхийг тусад нь олгодог. Нэг компанид бүс нутгийн нэг телевизийн үйлчилгээний эрх олгож болно. Тус компани (бүс нутгийн үйлчилгээний эрхтэй) мөн нэг болон түүнээс олон орон нутгийн үйлчилгээний эрхтэй байж болно. Гэхдээ (бүс нутгийн болон орон нутгийн) нийт үйлчилгээ нь энэ тохиолдолд 6 сая хүртэлх үзэгчдэд хүрч болох хязгаартай байдаг. Кабелийн телевизийн хувьд үндэсний эсвэл бүс нутгийн хэмжээнд 8 сая хүртэлх үзэгчидтэй байх хязгаартай байна.

Хэвлэл мэдээллийн олон төрлийн хэрэгслийн эзэмшлийн тухай дүрэм журам: Аливаа компани: 30 саяас дээш тооны үзэгч/сонсогчтой радио станцтай, 6 саяас дээш тооны үзэгчдэд хүрдэг радио эсвэл кабелийн телевизийн нэг ба түүнээс олон тусгай зөвшөөрөлтэй эсвэл 4 саяас дээш тооны үзэгчдэд хүрдэг телевизийн үйлчилгээний нэг ба түүнээс олон тусгай зөвшөөрөлтэй эсвэл улсын хэмжээнд борлуулалт нь 20%-иас дээш нэг ба түүнээс олон өдөр тутмын сонин эзэмшдэг, удирддаг бол радио телевизийн тусгай зөвшөөрөл нэмж олгодоггүй. Энэхүү хязгаарлалт нь улсын хэмжээнд болон бүс нутагт аль алинд нь хүчин төгөлдөр байна.

Хэвлэлийн газрууд радио телевизийн ашиг сонирхолтой бол өдөр тутмын сонины улсын хэмжээний борлуулалт нь 20% байна гэсэн хязгаарлалт байдаг.

Гадаадын эзэмшил/хөрөнгө оруулалтын дүрэм журам: Гадаадын хөрөнгө оруулагчид франц хэлээр нэвтрүүлэг цацдаг эсвэл хэвлэн нийтэлдэг хэвлэл мэдээллийн компанийн хөрөнгө буюу сонгох эрхийн 20 хүртэлх %-ийн хувьцааг эзэмших хязгаарлалт байдаг.

Хүртээмжийг хангах тухай хууль тогтоомж: цацалтын талбай, дотоод харилцаа, үндсэн техник хэрэгсэл: Харилцаа холбоонд шинээр орж, хувь нэмрээ оруулах хүсэлтэй этгээдүүдэд зориулан “Олон улсын үйлчилгээний санхүүгийн механизм”-ийг Франц улс бий болгожээ. Саяхан бий болгосон энэхүү мөнгөн сан нь хэрэглэгчид хоорондын татварын зардлыг тэнцвэржүүлэх замаар харилцаа холбооны салбар зах зээлийн хаалтгүй байх нөхцлийг хангах юм.

Өрсөлдөөний тухай хууль (ба түүнийг хэвлэл мэдээллийн хэрэгсэлд ашиглах байдал): 1986 оны **Өрсөлдөөний тухай захирамж № 86-1243**-т компаниуд холбогдох зах зээлийн нийт 25% эсвэл нэгдсэн эргэлтийн хөрөнгө нь 7 сая франц франкаас давсан компанийн нэгдэл эсвэл худалдан авалтанд оролцоход давамгайлсан байр суурь үүсдэг гэж заажээ.

Монопольчлолыг тодорхойлох хэмжигдэхүүнүүд ба арга зам: *Өрсөлдөөний Зөвлөх Хороо (Conseil de la Concurrence)* зах зээлийг хянаж хууль ёсны аливаа шилжилтийн талаар Эдийн засгийн Хэрэг эрхлэх Яаманд мэдэгддэг. Дараа нь яамнаас компанийн нэгдэл эсвэл худалдан авалтанд өөрийн хүсэлтээр оролцож буй талуудыг урьж яамны зөвшөөрөл олгох санал гаргадаг. *Өрсөлдөөний Зөвлөх Хороо* нь зохицуулах байгууллага биш бөгөөд бие даасан шийдвэр гаргагч биш гэдгийг тэмдэглэх нь зүйтэй. Өрсөлдөөний эсрэг үйлдлийн талаар гаргасан аливаа шийдвэрийг гол төлөв Эдийн засгийн Хэрэг эрхлэх Сайд гаргадаг. 1986 оны 11 сард Хэвлэл мэдээллийн тухай хууль гарснаас хойш хэвлэл мэдээллийн салбарыг Эзэмшлийн тухай тодорхой хуулиар зохицуулдаг учраас өрсөлдөөний тухай ерөнхий хуулийг төдий л хэрэглэдэггүй. Хэвлэл мэдээллийн хэрэгслийн эзэмшлийн тухай хууль нь зах зээлийн төвлөрлийг зохицуулах боломжгүй болох үед мэдээж хэрэг Өрсөлдөөний тухай ерөнхий хуулийг мөрдөнө.

Өрсөлдөөний тухай хуулийг хэвлэл мэдээллийн салбарт мөрддөгийн адил радио телевизийн салбарт мөн хэрэглэгдэнэ. Хэрвээ салбарын тусгай хууль байхгүй бол *Төвлөрлийг хянах тухай хууль № 77-806, 1986 оны Өрсөлдөөний тухай захирамж № 86-1243-д* заасан өрсөлдөөний хуулийг радио телевизийн салбарт мөрдөнө. *Conseil Supérieur de l'Audiovisuel* хууль тогтоомжийг нь зөрчиж монополь байр сууриа хууль бусаар ашигласан аливаа тохиолдлыг *Өрсөлдөөний Зөвлөх Хороо* ба *Эдийн засгийн Хэрэг эрхлэх Яаманд* мэдэгдэх ба авах арга хэмжээг санал болгож болдог.

Олон нийтийн ашиг сонирхлын тухай заалтууд (бүс нутгийн хөтөлбөр, нийгмийн бүлгүүдийн төлөөлөл гэх мэт): Бүс нутгийн болон орон нутгийн телевиз, радиогийн нэвтрүүлгийн агуулгад плюралист төлөөллийг хангахын тулд татаас олгодог.

Хэвлэл мэдээллийн хэрэгслийн эзэмшил ба төвлөрлийн асуудал дахь зохицуулах хороо, байгууллагуудын эрх мэдэл: Хэвлэл мэдээллийн хэрэгслийн эзэмшилийн тухай хуулиудыг зөрчсөн радио, телевизийн тусгай зөвшөөрөлийг *Conseil Supérieur de l'Audiovisuel* цуцалж болно. Давамгайллын байр сууриа буруугаар ашиглах тохиолдолд *Эдийн засгийн хэрэг эрхлэх сайд* (CSA эсвэл *Эдийн засгийн хэрэг эрхлэх яам*, эсвэл *Өрсөлдөөний зөвлөх хорооны* аль алинаас нь санал авсны дараа) зах зээл дэх төвлөрлийг хааж болно.

Ирээдүйн зохицуулалтын санал ба чиг хандлага: Франц улс **1996 оны Мэдээллийн хэт хурдны замын тухай хууль № 96-299**-ийн дагуу дижитал болон видеог хүссэнээр гаргах үйлчилгээний туршилтын тусгай зөвшөөрөлийг одоо олгож байна. 3, 4-р заалт нь радио телевизийн тухай хуулиуд № 86-1064 ба №94-88-ийг мөрддөг боловч хүссэнээр видео гаргах үйлчилгээг №86-1064 хуулийн 27, 28, 28-1, 70 7-р зүйлүүдээр чөлөөлдөг байна (агуулгатай нь холбоотой). Дижитал телевизийн зөвшөөрөл тусгай зөвшөөрөлийг CSA-ийн саналаар олгодог.

1997 онд Францын засгийн газар 1994 оны Радио телевизийн тухай хуулинд өөрчлөлт оруулжээ. Гэхдээ тус оны 6 сард засгийн газарт өөрчлөлт орсон учраас энэ талаар санал хурааж амжаагүй юм. Шинэ засгийн газар одоогоор хэвлэл мэдээллийн хэрэгслийн төвлөрлийн хэмжээнд сэтгэл хангалуун бус байгаа бөгөөд хэвлэл мэдээллийн хэрэгслийн эзэмшилийн хязгаарыг 1986 оных шиг 25% болгох хүсэлтэй байгаагаа илэрхийлсэн байна (одоогоор энэ нь 49% байгаа юм). Хэдий тийм боловч төвлөрлийг задлах боломж байхгүйгээс шалтгаалан ингэж дахин зохицуулах боломж маш бага байгаа юм.

Хоёр. ХБНГУ

Хэвлэл мэдээллийн компанийн эзэд/хувьцаа эзэмшигчдийг нэрлэхэд тавигдах шаардлагууд (нэрлэсэн хувьцаа): Хувьцааг нэрлэсэн байхыг шаардсан хууль Герман улсад байдаггүй.

1987 оны Худалдааны хуулиар компаниуд удирдах зөвлөлийн бүх гишүүдийн нэрс болон толгой компаний нэрийг өгөх шаардлагатай.

Улс орны болон бүс нутгийн хэмжээнд нэвтрүүлгээ цацах хувийн радио телевизийн тусгай зөвшөөрөл авах хүсэлт гаргагчид удирдах зөвлөлийн гишүүд, мэдээллийн хэрэгслийн эзэмшигчдийн нэрс болон компаниуд, тэдэнтэй ямар харилцаатайгаа мөн ил болгох ёстой.

Компанийн данс тайланг ил болгох шаардлагууд: 1987 оны Худалдааны хуулинд зааснаар компанийн нэгдсэн тайланг олон нийтэд ил болгох ёстой.

1965 оны Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиар компанийн хэлбэрээс шалтгаалан тодорхой хэмжээгээр компанийн данс тайланг хэвлэн нийтлэх шаардлагыг тавьжээ.

Улсын хэвлэл нийтлэлийн тухай хуулинд хэвлэлийн газрууд сониндоо ажилтнуудынхаа нэрсийн жагсаалт (редактор болон сонины эзнийг оруулна), үйл ажиллагаа болон борлуулалтын талаар нийтлэхийг заасан байдаг.

Хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийн орлогын эх үүсвэрийг ил болгох шаардлагууд: Герман улсад санхүүгийн эх сурвалжаа (зарлал сурталчилгааг оруулна) бүрэн ил болгохыг шаардсан хууль байдаггүй.

Хувьцаа, хөрөнгө болон хувьцаа эзэмшилд гарсан өөрчлөлтийг зохицуулах хороо, албанд мэдэгдэх шаардлагууд: 1965 оны холбооны Корпорацийн тухай хуулинд зааснаар компаниудын хувьцаа эзэмшил 25% эсвэл 50%-д хүрмэгц нэн даруй олон нийтэд зарлан мэдэгдэх ёстой.

1996 оны Муж хоорондын радио телевизийн хэлэлцээрийн дагуу радио телевизийн компанийн удирдах зөвлөлд өөрчлөлт гарах нь тусгай зөвшөөрөлд нөлөөлж болзошгүй учраас энэ тохиолдолд холбогдох зохицуулах хороонд мэдэгдэх ёстой.

Хэвлэл мэдээллийн хэрэгслийн эзэмшилтэй холбоотой хууль тогтоомж: тусгай зөвшөөрөл олгоход тавигдах шаардлагууд, ерөнхий зөвлөл дэх нийгмийн бүлгүүдийн төлөөлөл: Grundgesetz-д зааснаар Герман улсын мужууд хэвлэл мэдээллийн тухай журмыг багтаасан соёлын журамтай байх ёстой (30 ба 70-р зүйл). Холбооны хэвлэл мэдээллийн тухай хууль гэж байдаггүй. Хэвлэл мэдээллийн салбар нь 16 өөр мужийн хэвлэл мэдээллийн тухай хуулиар зохицуулагддаг (Landespressegesetze).

16 мужийн бүх Хэвлэл мэдээллийн тухай хууль нь хэвлэн нийтлэлийн үүсгэн байгуулах эрхийг хангадаг бөгөөд энэ нь тусгай зөвшөөрөл гэж байдаггүй гэсэн үг юм. Хэвлэл нийтлэлийн борлуулалтанд хязгаар байдаггүй, хэвлэл нийтлэлийн өөр өөр зах зээлд ялгаа байдаггүй аж.

1973 оны Хязгаарлагдмал практик ажиллагааны тухай хуулинд эргэлтийн хөрөнгийн хязгаарыг тогтоосноос өөр Мужаас тогтоосон эзэмшилийн тухай заалт хэвлэл мэдээллийн секторт байдаггүй. Олон жилийн турш олон тооны үндэсний хэвлэл мэдээллийн комисс байгуулж хэвлэл мэдээллийн үзүүлэх нөлөөний талаар судалгаа хийж байжээ. Холбооны шүүхийн санал болгосны дагуу хэвлэл мэдээллийн төвлөрлийг мэдээллийн эрх чөлөөнд заналхийлдэг гэж үздэг учраас эзэмшилийн тухай хууль тогтоомж санал болгожээ. Гэхдээ мужууд эдгээр саналыг авч хэлэлцээгүй байна.

1996 он хүртэл улсын хэмжээнд нэвтрүүлгээ цацах эсвэл мэдээний сувгийн тусгай зөвшөөрөл эзэмшиж буй компаниудад хувьцааны 50 хүртэлх хувийг эзэмших хязгаар тогтоосон бөгөөд мөн хоёр телевизийн суваг, 2 радио станцтай байх хязгаарлалт байжээ. Телевизийн эдгээр хориг хязгаарлалт нь 1996 оны Муж хоорондын радио телевизийн хэлэлцээрээр хүчингүй болсон байна. Шинэ дүрэм журмын дагуу хувьцаа эзэмшигчид радио телевизийн компанийн хөрөнгийг 100% эзэмшихийг зөвшөөрсөн байна (үндэсний

радио сувгийн 50% гэсэн хязгаарлалт хүчинтэй хэвээрээ байна). Хувь хүний эзэмшиж болох телевизийн сувгийн тоонд хязгаарлалт байхаа больжээ. Оронд нь бодлого журмын шинэ хэрэгсэл бий болжээ: энэ нь тухайн компанийн эзэмшдэг телевизийн бүх сувгууд нь улсын хэмжээнд нийт үзэгчдийн 30 хүртэл %-д байна гэсэн лимит юм.

Хэвлэл мэдээллийн олон төрлийн хэрэгслийн эзэмшлийн тухай дүрэм журам: Герман улсад олон улсын хэвлэл мэдээллийн хэрэгслийн эзэмшлийг хязгаарлах улсын хэмжээний хориг байдаггүй. Гэхдээ мужууд орон нутгийн болон бүс нутгийн радио телевизийн хувьцааг хэвлэлийн газрууд эзэмшихийг хориглох эрхтэй байна.

Гадаадын эзэмшил/хөрөнгө оруулалтын дүрэм журам: Хэвлэл мэдээллийн компаниудыг гадаад хүн/байгууллага эзэмших талаар ямар нэг хориг байдаггүй боловч радио телевизийн компаниуд Герман улсад үүсгэн байгуулагдсан байх ёстой.

Өрсөлдөөний тухай хууль (ба түүнийг хэвлэл мэдээллийн хэрэгсэлд ашиглах байдал): Grundgesetz-ийн 73, 74, 75, 79-р зүйлд зааснаар Холбооны засгийн газар нь эдийн засгийн хуулиудыг хэрэгжүүлэх ажлыг хариуцдаг. Тийм учраас хэвлэл мэдээллийн эзэмшлийн тухай Мужийн хуулиас гадна өрсөлдөөний тухай хууль нь холбооны хэмжээнд хүчин төгөлдөр байна. 1980 оны *Хязгаарлагдмал практик ажиллагааны тухай хуулиар* нэмэлт өөрчлөлт оруулсан 1973 оны *Хязгаарлагдмал практик ажиллагааны тухай хууль* гарснаар анх өрсөлдөөний тухай хуулийг бий болгосон байна.

Монопольчлолыг тодорхойлох хэмжигдэхүүнүүд ба арга зам: Эдийн засгийн бусад секторуудтай харьцуулахад хэвлэл мэдээллийн салбарын эргэлтийн хөрөнгийн босго нь арай бага байдаг (Хэвлэл мэдээллийн секторынх жилд 25 сая дойч марк байхад бусад бүх секторуудын жилийн эргэлт 500 сая дойч марк байдаг). Гэхдээ энэхүү босгыг Картелийн Албаны гаргасан шийдвэрт байнга мөрдөөд байдаггүй бөгөөд хэвлэл мэдээллийн төвлөрөл нь босгыг давах нөхцөл байдалд хүргэж байна (Европын Холбоо үүнийг эсэргүүцсээр ирсэн).

Өрсөлдөөний тухай хууль радио телевизэд мөн хэрэгждэг боловч (хэвлэл мэдээлэлтэй харьцуулахад) ямар нэг тусгай зүйл заалт (эргэлтийн хөрөнгийн босгын хувьд) байдаггүй. Хэвлэл мэдээллийн салбартай адил Герман улсын радио телевизийн салбарын төвлөрлийг хязгаарлах хориг нь тийм хатуу чанга биш байдаг. Герман улсын Картелийн Албанаас хэвлэл мэдээллийн хэрэгслийн төвлөрлийг дэмжин гаргасан олон шийдвэрийг Европын Холбоо эсэргүүцэж байлаа.

Хэвлэл мэдээллийн компаниудад төрийн дэмжлэг үзүүлэх, татаас олгох: Герман улсын хуулийн дагуу хэвлэл мэдээллийн хэрэгсэлд шууд татаас өгөхийг хориглодог. Харин тодорхой нөхцлийн дагуу шуудангийн хөнгөлөлттэй үнэ (мэдээний тогтмол хэвлэлд), хөрөнгө оруулалтын зээл (сонин, сэтгүүлд) хэлбэрээр шууд бус татаасыг олгож болдог (эдгээр хэвлэл нь ихэвчлэн сургалт хүмүүжлийнх байдаг).

Засгийн газрын нөлөөллийг хязгаарлах зорилгоор хувийн радио телевизэд төрөөс татаас олгохыг (өмнө нь ч одоо ч) хориглодог. Гэхдээ Германы муж улсууд бие даасан продакшн компаниудад кино, нэвтрүүлэгт нь зориулж татаас олгодог. Санхүүжилтийг *Муж хоорондын радио телевизийн хэлэлцээр* (Rundfunkstaatsvertrdge)-ийн дагуу Мужаас зөвшөөрсөн байдаг.

Хэвлэл мэдээллийн хэрэгслийн эзэмшил ба төвлөрлийн асуудал дахь зохицуулах хороо, байгууллагуудын эрх мэдэл: Төвлөрөл болон хэвлэл мэдээллийн

хэрэгслийн эзэмшлийн тухай хуулиудыг 16 муж (Laender) хүлээн зөвшөөрсөн. 1987 онд анхны *Радио телевизийн бүтцийн өөрчлөлтийн тухай муж хоорондын хэлэлцээр*-ийг баталжээ. Түүний дараа 1991 оны *Радио телевизийн муж хоорондын хэлэлцээр*-ээр өмнөх бүх салангид хэлэлцээрүүдийг (радио болон олон нийтийн үйлчилгээний тухай гэрээ хэлцлүүд г.м) нэгтгэсэн байна. Одоогийн байдлаар Германы муж улсууд (Laender) *1996 оны Радио телевизийн муж хоорондын хэлэлцээр* (Rundfunkstaatsvertrag)-ээр радио телевизийн үйл ажиллагааг зохицуулдаг.

1996 оны Радио телевизийн муж хоорондын хэлэлцээр-ээр үндэсний радио телевизийн зөвшөөрөл тусгай зөвшөөрөл олгох, хянах (мөн агуулгыг) зорилгоор Хэвлэл мэдээллийн салбарын Төвлөрлийг хянан шалгах хороог байгуулжээ. Мужийн хуулийг зөрчсөн аливаа тохиолдолд тус хороо нь радио телевизийн тусгай зөвшөөрөлийг хүчингүй болгох эрхтэй.

Холбооны Картелийн Алба нь давамгайл байр суурийг хууль бусаар ашиглах асуудлыг хянаж зохицуулдаг. Хамгийн сүүлийн шийдвэрийг Эдийн засгийн Хэрэг эрхлэх Сайд баталдаг. Компаниудын нэгдлийг болиулж, торгууль төлбөр тавьж болно.

Ирээдүйн зохицуулалтын санал ба чиг хандлага: Герман улсад зах зээлийн бүрэн чөлөөт байдал, төрийн зохицуулалтгүй байдлын төлөөх хандлага илэрхий байсаар ирсэн. Энэ нь хэвлэл мэдээллийн хөрөнгө оруулалтыг татахыг хичээхдээ Laender-ууд хооронд төрийн зохицуулалтыг халах өрсөлдөөн явагддагаас улбаатай. Гэхдээ хэвлэл мэдээллийн хэрэгслийн бодлогыг хариуцдаг Laender болон харилцаа холбооны бодлогыг хариуцдаг холбооны засгийн газар хооронд төрийн зохицуулалтын талаарх тэмцэл мөн байдаг. Техник технологийн нэгдэл нь ирээдүйд хэвлэл мэдээллийн зах зээлүүд харилцаа холбооны хэрэгслийн адил зохицуулагдана гэсэн үг учраас Laender зохицуулалтын эрх мэдлээ холбооны засгийн газарт өгөх хэрэгтэй болно гэсэн баримтлал байна.

Гурав. Итали Улс

Хэвлэл мэдээллийн компанийн эзэд/хувьцаа эзэмшигчдийг нэрлэхэд тавигдах шаардлагууд (нэрлэсэн хувьцаа): 1981 оны Хэвлэл мэдээллийн тухай хуулийн Нэгдүгээр бүлэгт заасны дагуу хэвлэлийн газрууд сонин сэтгүүлээ *Харилцаа холбооны операторуудын бүртгэлд* (орон тооны 5-аас дээш сэтгүүлчтэй) бүртгүүлэх ёстой ба *Харилцаа Холбооны Албанд* жил бүр хуулинд заасан шаардлагуудын дагуу санхүүгийн тайлан гаргаж өгөх ёстой. Эдгээр санхүүгийн тайланг мөн компанийн хэвлэл нийтлэлд жил бүр нийтэлж байх ёстой.

Радио телевизийн тусгай зөвшөөрөл эзэмшиж буй компаниуд *Харилцаа холбооны операторуудын бүртгэлд* хувь нийлүүлэгчдийн (2%-иас дээш) нэрс, тэдний хувьцааны тоо, тэдгээр хувьцааны үнэ зэргийг оруулах ёстой.

Хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийн орлогын эх үүсвэрийг ил болгох шаардлагууд : 1981 оны Хэвлэл мэдээллийн тухай хуулинд заасан шаардлагын дагуу хэвлэлийн компаниуд жил бүр санхүүгийн тайлангаа *Харилцаа Холбооны Албанд* гаргах ёстой. Хэвлэлийн газрууд эдгээр санхүүгийн тайланг өөрийн хэвлэлдээ нийтлэх ёстой.

Радио телевизийн компаниуд жил бүрийн санхүүгийн тайлан балансаа *Харилцаа Холбооны Албанд* гаргах ёстой. Компанийн орлогын (хэвлэл захиалга, зар сурталчилгаа, санхүүжилт) мэдээллийг энэхүү жил бүрийн тайланд хавсаргах ёстой.

Хувьцаа, хөрөнгө болон хувьцаа эзэмшилд гарсан өөрчлөлтийг зохицуулах хороо, албанд мэдэгдэх шаардлагууд: Хэвлэлийн компаниудын хувьцааны аливаа шилжүүлгийн талаар *Харилцаа Холбооны Албанд* хэвлэл мэдээллийн компаниуд нэн даруй мэдэгдэх ёстой.

Радио телевизийн компаниудын хөрөнгийн 10 хувиас дээш хэмжээний хувьцааг шилжүүлэх тохиолдолд *Харилцаа Холбооны Албанд* мэдэгдэх ёстой. Хөрөнгийн биржид бүртгэгдсэн дээр компаниуд хөрөнгийнхөө 2%-иас дээш хэмжээний хувьцааг шилжүүлэх тохиолдолд мэдэгдэх ёстой.

Хэвлэл мэдээллийн хэрэгслийн эзэмшилтэй холбоотой хууль тогтоомж: тусгай зөвшөөрөл олгоход тавигдах шаардлагууд, нийгмийн бүлгүүдийн төлөөлөл: 1981 оны Хэвлэл мэдээллийн тухай хуулинд заасан зах зээлийн хувь хэмжээний тухай дүрэм журмаар хэвлэлийн газруудын борлуулалт улсын хэмжээнд 20%, бүс нутгийн хэмжээнд 50% байх хязгаартай байдаг.

1990 оны Радио телевизийн тухай хуулинд улсын болон бүс нутгийн хэмжээнд эзэмшилийн дүрэм журмыг ялгаатайгаар гаргажээ. Нэг компани улсын хэмжээний радио телевизийн суваг 3-аас олныг эзэмших эрхгүй. Мөн эзэмшиж буй сувгууд нь улсын хэмжээний бүх радио телевизийн сувгуудын 25%-иас бүрддэг бол зөвхөн 2 суваг эзэмших эрхтэй байдаг. Компани улсын радио телевизийн зах зээлийн нийт орлогын 25 хүртэлх %-г эзэмших хязгаарлалт байдаг (улсын радио телевизийн зах зээлийн нийт орлогыг хэзээ ч бодитойгоор тооцох боломжгүй учраас энэхүү дүрэм практикт хэрэгжиж байгаагүй). Нэвтрүүлгээ өөр өөр бүс нутагт цацдаг бол бүс нутгийн 3 сувгаар орон нутгийн телевизийн тусгай зөвшөөрөл нь хязгаарлагддаг. Хэрэв тус 3 бүс нутаг нь хиллэн оршдог бол нийт хүн ам нь 10 саяас илүүгүй байх ёстой. Орон нутгийн радиогийн тусгай зөвшөөрөлийн хувьд улс даяар 7 тусгай зөвшөөрөлтэй буюу 10 сая сонсогчдод хүрдэг, харин бүс нутагт 1 тусгай зөвшөөрөлтэй байх хязгаартай.

Нэг жилийн хугацаанд томоохон өөрчлөлт гарсан тохиолдолд компанийн радио телевизийн тусгай зөвшөөрөлийг дахин баталгаажуулах ёстой (корпорацийн хувьд 2 ба түүнээс дээш %, бусад тохиолдолд 10%).

1990 оны 8-р сарын 6-ны Радио телевизийн тухай хуулиар Олон нийтийн Зөвлөгөөний Хороог байгуулсан бөгөөд *Харилцаа Холбооны Албаны* харьяанд үйл ажиллагаа явуулдаг.

Хэвлэл мэдээллийн олон төрлийн хэрэгслийн эзэмшилийн тухай дүрэм журам: 1990 оны Радио телевизийн тухай хуулиар 16 хувиас дээш борлуулалттай хэвлэлийн компаниудыг телевизийн суваг эзэмшихээс, 8-аас дээш хувийн борлуулалттайг нь нэгээс дээш тооны суваг эзэмшихээс сэргийлж хэвлэл мэдээллийн олон төрлийн хэрэгслийн эзэмшилд хязгаар тогтоодог. Улсын хэмжээнд 8%-иас доош борлуулалттай хэвлэлийн компани 2 телевизийн суваг эзэмших эрхтэй байдаг. Улсын хэмжээний телевизийн тусгай зөвшөөрөл эзэмшигчийг орон нутгийн телевиз, радиогийн сувгийн тусгай зөвшөөрөл эзэмшихийг хориглодог (эсргээр мөн адил). Орон нутгийн телевизийн тусгай зөвшөөрөл эзэмшигч нь орон нутгийн үелзлийн хуваарилалт хомсдолгүй бол орон нутгийн радио сувгийн тусгай зөвшөөрөл эзэмшиж болдог.

Гадаадын эзэмшил/хөрөнгө оруулалтын дүрэм журам: 1981 оны Хэвлэл мэдээллийн хуулиар сонин сэтгүүлийн хэвлэлийн компани (эсвэл томоохон хувь

нийлүүлэгч) эсвэл хэвлэлийн агентлагт (5 ба түүнээс дээш ажилтантай) хилийн чанадад компани бүртгүүлэхийг хориглодог.

1990 оны Радио Телевизийн тухай хуулиар Европын Холбоон дотор (буюу түүнтэй төстэй худалдааны гэрээтэй орнуудад) хуулийн этгээдийн гадаадын эзэмшлийг хязгаарладаггүй. Гэхдээ Европын Холбооноос гадна байрлах хуулийн этгээдэд радио телевизийн компанид олонх хувьцаа эзэмшихийг зөвшөөрдөггүй.

Радио телевизийн тусгай зөвшөөрөлийг зөвхөн Итали улсаас нэвтрүүлгээ цацдаг компаниудад л олгодог.

Хүртээмжийг хангах тухай хууль тогтоомж: цацалтын талбай, дотоод харилцаа, үндсэн техник хэрэгсэл: 1999 онд Итали улс шинээр элсэгчдэд харилцаа холбооний сүлжээнд хандах боломжийг баталгаажуулах зорилгоор олон нийтийн үйлчилгээний мөнгөн сан байгуулжээ. Энэхүү мөнгөн санг 1998 оны харилцаа холбооны операторуудын үр дүн дээр үндэслэсэн юм.

Монопольчлолыг тодорхойлох хэмжигдэхүүнүүд ба арга зам: 1947 оны Итали улсын Иргэний хуулинд монополь байр суурийг тодорхойлжээ. Тухайлбал Иргэний хуулийн 2359-р зүйлд аливаа хуулийн этгээд нь компаний сонгох эрхийн 50 ба түүнээс дээш %-ийг эзэмшиж буй тохиолдолд монопольчлол (хяналт) үүсдэг гэжээ.

1990 оны Өрсөлдөөний тухай хуулинд тухайн зах зээлийн орлогын 50%-д хүрсэн тохиолдолд холдингийг монополь гэж үзнэ гэжээ. Уг хууль нь монополь байр суурийг хориглодоггүй боловч хэрвээ компани зах зээлд монополь байр суурь эзэлбэл Монопольчлолын Албанаас тухайн компанийн үйл ажиллагаанд (үйл ажиллагаагаа нэмж өргөжүүлэхийг хориглох, гэрээг цуцлах гэх мэт) тодорхой хязгаарлалт тавьдаг.

Хэвлэл мэдээллийн компаниудад төрийн дэмжлэг үзүүлэх, татаас олгох: 1981 оны Хэвлэл мэдээллийн тухай хуулиар хэвлэл мэдээлэлд татаас олгох талаар дүрэм журам тогтоожээ. Хэвлэлийн компаниудад бага татвар ногдуулах, тээвэр, шуудан, харилцаа холбооны төлбөрийг бага тогтоох замаар шууд бус татаасыг олгодог. Шууд татаасыг ашгийн бус хэвлэл, сэтгүүлчдийн холбоо, жижиг хэвлэлүүд болон улс төрийн намын хэвлэлд олгодог.

Зарим тохиолдолд шууд бус татаасыг радио телевизэд (харилцаа холбоо, цахилгаан) нийтийн үйлчилгээний үнийг бага тогтоох замаар олгодог. Шууд татаасыг шинэ агентлагуудын төлбөрт олгодог (төлбөрийн 53 хүртэлх %).

Олон нийтийн ашиг сонирхлын тухай заалтууд (бүс нутгийн хөтөлбөр, нийгмийн бүлгүүдийн төлөөлөл): 1981 оны Хэвлэл мэдээллийн тухай хууль № 416-аар бүс нутгийн болон нийгмийн тодорхой ашиг сонирхлыг төлөөлж буй хэвлэл мэдээлэлд санхүүжилт олгох тухай заажээ (гэхдээ үүнд улс төрийн намууд ордог).

1990 оны Радио телевизийн тухай хуулинд аливаа радио телевиз нэвтрүүлгийн цагийнхаа 4%-ийг Европын эх сурвалжаас авсан байх ёстой гэж заажээ. Энэ нь компаний тусгай зөвшөөрлийн эхний 3 жилийн хугацаанд хэрэгждэг. 3 жилийн дараа нэвтрүүлгийн 51 хувийг Европын эх сурвалжаас авсан байх ба түүний 50%-ийг Итали эх сурвалжаас авсан байх ёстой.

Хэвлэл мэдээллийн хэрэгслийн эзэмшил ба төвлөрлийн асуудал дахь зохицуулах хороо, байгууллагуудын эрх мэдэл: 1987 оны Хэвлэлийн хуулинд хэвлэлийн газар монополь байр суурьтай болсон тохиолдолд Парламент тухайн компанийн хувьцааг хүчингүй болгох эрхтэй гэж заажээ (уг байдлыг засахад компанид 6-12 сарын хугацаа өгдөг).

Монополь байр суурь эзэлж байгааг тогтоовол Өрсөлдөөн зохицуулах албанаас тухайн компанийн үйл ажиллагаанд хязгаарлалт (үйл ажиллагаагаа нэмж өргөжүүлэхийг хориглох, гэрээг цуцлах гэх мэт) тогтоож болно. Тус Алба нь 1996 онд тогтоосон босгыг давах компанийн нэгдэл ба худалдан авалтыг зогсоох эрхтэй.

Харилцаа холбооны Алба хэвлэл мэдээллийн хэрэгслийн (харилцаа холбоо, мэдээллийн үйлчилгээг оруулан бүх хэвлэл мэдээллийн хэрэгслийн) нэгдэл, худалдан авалтыг хянадаг бөгөөд зах зээлийн зохисгүй төвлөрлийн талаар өрсөлдөөн зохицуулах албанд мэдээлдэг. Өрсөлдөөн зохицуулах алба нь *Харилцаа холбооны Алба*-наас ирсэн саналын дагуу арга хэмжээ авдаг. *Харилцаа холбооны Алба* нь хэвлэл мэдээллийн салбартай холбоотой бодлого журмыг Парламентэд санаачлах эрхтэй.

Ирээдүйн зохицуулалтын санал ба чиг хандлага: Одоогоор засгийн газар 1981 оны Хэвлэл мэдээллийн тухай хуулийг шинэчлэхээр төсөл боловсруулж байна. Хуулийн төсөл нь төвлөрөл болон хэвлэл мэдээллийн олон төрлийн хэрэгслийн эзэмшилийг нэмэгдүүлэхийн тулд эзэмшилийн хязгаарыг чөлөөлөх, хэвлэл мэдээллийн секторыг чөлөөлөхөд чиглэж байна. Ил тод байх шалгуур хэмжүүрийг чангатгах ажээ.

Дөрөв. Нидерланд улс

Хэвлэл мэдээллийн компанийн эзэд/хувьцаа эзэмшигчдийг нэрлэхэд тавигдах шаардлагууд (нэрлэсэн хувьцаа): Бүх хувьцааг нэрлэн бүртгүүлэх ёстой.

Компанийн данс тайланг ил болгох шаардлагууд: Компанийн тухай ерөнхий хуулинд зааснаар бүх компаниуд (мөн хэвлэл мэдээллийн бус) жил бүр данс тайлангаа хэвлэн нийтлэх ёстой.

Хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийн орлогын эх үүсвэрийг ил болгох шаардлагууд: Commissariaat voor de Media-гийн хүсэлтээр компаниуд данс тайлангаа шалгуулахыг зөвшөөрөх ёстой. Хэвлэл мэдээллийн хэрэгслийн орлогыг мөн компанийн данс тайлангийн хэвлэлд оруулж ил болгосон байх ёстой.

Хувьцаа, хөрөнгө болон хувьцаа эзэмшилд гарсан өөрчлөлтийг зохицуулах хороо, албанд мэдэгдэх шаардлагууд: Компанийн тухай хуулийн дагуу бүх компаниуд хувьцааны томоохон өөрчлөлтийг олон нийтэд (сонинд) тайлагнах ёстой. Хувьцааны томоохон өөрчлөлт гэдэг нь хувьцаа эзэмшигч компанийн хувьцааны 5, 10, 25, 50 ба 66 хувьд хүрэхийг хэлнэ.

Хэвлэл мэдээллийн хэрэгслийн эзэмшилтэй холбоотой хууль тогтоомж: тусгай зөвшөөрөл олгоход тавигдах шаардлагууд, нийгмийн бүлгүүдийн төлөөлөл: Нидерландын хэвлэлийн компаниуд хэвлэл мэдээллийн зах зээлийн хувь хэмжээнд өөрсдөө зохицуулалт хийдэг. 1993 онд Нидерландын хэвлэлийн компаниуд хэвлэл нийтлэлээ сонины улсын зах зээлийн 1/3 хүртэл хэмжээнд байх хязгаар тогтоохоор шийдвэрлэжээ.

Хувийн радио станцуудад 1988 оны Нидерландын Хэвлэл мэдээллийн хэрэгслийн тухай хуулийн заалтуудын дагуу тусгай зөвшөөрөл олгодог.

1990 оны Хэвлэл мэдээллийн хэрэгслийн тухай хуулиар анх удаа хувийн радио телевизүүдийг зөвшөөрсөн, гэхдээ хувийн радио телевизийг зөвхөн кабелиар нэвтрүүлгээ дамжуулахыг заасан байна. Газраас дамжуулах бүх үелзлүүдийг олон нийтийн станцууд ашигладаг. Хувийн телевизүүд орон нутгийн кабелийн сүлжээгээр улс даяар нэвтрүүлгээ цацдаг. Кабелийн тусгай зөвшөөрөлийг Соёлын яамнаас олгодог бөгөөд орон нутгийн захиргаа бүрт шаардлагатай (Нидерланд улсад орон нутгийн 700 гаруй захиргаа байдаг). Зөвхөн орон нутагт болон бүс нутгийн түвшинд нэвтрүүлгээ цацахыг олон нийтийн үйлчилгээ үзүүлэгчдэд хориглодог.

Хэвлэл мэдээллийн олон төрлийн хэрэгслийн эзэмшлийн тухай дүрэм журам: 1990 оны Хэвлэл мэдээллийн хуулинд 60%-иас дээш үзэгчтэй радио телевиз улсын хэмжээнд 25%-иас дээш уншигчдад хүрдэг сонин эзэмших эрхгүй гэсэн хэвлэл мэдээллийн олон төрлийн хэрэгслийн эзэмшлийн тухай заалтууд орсон байдаг. Хувийн компаниудын дотоод эзэмшилд ямар нэг хязгаарлалт байдаггүй (100%-н эзэмшилтэй байж болно).

Гадаадын эзэмшил/хөрөнгө оруулалтын дүрэм журам: 1988 оны Хэвлэл мэдээллийн тухай хуулийн дагуу хувийн компаниуд Европын Холбооны гишүүн оронд үүсгэн байгуулагдсан байх ёстой.

Өрсөлдөөний тухай хууль (ба түүнийг хэвлэл мэдээллийн хэрэгсэлд ашиглах байдал): Монополь байр суурийг хууль бусаар ашигласан нь тогтоогдвол Нидерландын өрсөлдөөн зохицуулах албанаас 1 сая хүртэлх гульд эсвэл компаний эргэлтийн 10%-тай тэнцэх торгууль тогтоож болно. 1998 оноос өмнө ийм төрлийн шийдвэрийг зөвхөн Нидерландын Эдийн засгийн хэрэг эрхлэх сайд гаргадаг байв. Одоо Өрсөлдөөн зохицуулах албаны ерөнхий захирал ийм шийдвэрийг бие даан гаргадаг болсон. Нидерландын компаниудад мөн хувьцааны томоохон өөрчлөлт эсвэл компаниудын нэгдэл, худалдан авалт зэргийн талаар үйлдвэрчний эвлэл, ажлын зөвлөлд мэдэгдэхийг шаарддаг Нидерландын корпорацийн уламжлал нөлөөлсөн байдаг .

Өрсөлдөөний тухай хуулийн дагуу хэвлэл мэдээллийн төвлөрлийн талаар тусгай заалтууд байдаг.

Монопольчлолыг тодорхойлох хэмжигдэхүүнүүд ба арга зам: Компаниудын нийт эргэлт эсвэл хамтарсан компанийн эргэлт 10 сая нидерланд гульдээс давах (гол орлого нь бараа материалаар орж ирсэн бол) эсвэл (бусад тохиолдолд) 2 сая нидерланд гульдээс давбал монополь байр суурийн хууль бус ашиглалтыг мөрдөн шалгаж болно. Мөн хамтарсан компанид найм ба түүнээс олон компаниуд оролцсон бол мөрдөн шалгалт явуулж болно.

Хэвлэл мэдээллийн компаниудад төрийн дэмжлэг үзүүлэх, татаас олгох: Эдийн засгийн хувьд оршин тогтнох чадваргүй сонинууд бие даасан Хэвлэл мэдээллийн Мөнгөн сангаар дамжуулан татаас (телевизэд татвар ноогдуулж авсан) авдаг. 1980 онд НӨАТ-ыг 6% -аар тогтоох хүртэл сонинууд НӨАТатвараас чөлөөлөгддөг байсан.

Ирээдүйн зохицуулалтын санал ба чиг хандлага: 1998 оны 10-р сард Нидерланд улс Харилцаа холбооны тухай шинэ хууль баталжээ. Энэхүү хуулийн заалтууд нь 1988 оны Хэвлэл мэдээллийн хэрэгслийн тухай хуулинд өөрчлөлт оруулжээ.

Үүнд орон нутгийн болон бүс нутгийн хэмжээний хувийн радио телевизүүдийн тусгай зөвшөөрөл болон олон нийтийн радио телевизүүдийн шинэ үйлчилгээний талаар заалтууд оруулсан байна.

Тав. Их Британи

Хэвлэл мэдээллийн компанийн эзэд/хувьцаа эзэмшигчдийг нэрлэхэд тавигдах шаардлагууд (нэрлэсэн хувьцаа): Компаниуд Бие даасан Телевизийн Хороо (ITC), Радиогийн Албанд тусгай зөвшөөрөл хүсэн өргөдөл гаргахдаа эзэмшигч, хувь нийлүүлэгчдийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг гаргаж өгөх ёстой.

ИБУИНВУлсын олон нийтийн бүх компаниуд хувь нийлүүлэгчдийн бүртгэлийг гаргаж өгөх ёстой. 3%-иас дээш хувьцаа эзэмшигчийг компанийн тухай журмын дагуу нэрлэх ёстой байдаг.

Компанийн данс тайланг ил болгох шаардлагууд: Хувьцаат компаниуд Companies House-д данс тайлангаа гаргаж өгөх ёстой ба тус байгууллага олон нийтэд ил болгодог. Тодорхой орлого бүхий хязгаарлагдмал бус компаниуд мөн Companies House-д данс тайлангаа гаргаж өгөх ёстой байдаг.

Хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийн орлогын эх үүсвэрийг ил болгох шаардлагууд: ИБУИНВУлсын хуулинд компаний данс тайланг бүртгүүлэхээс өөр ямар нэг шаардлага, нөхцөл байдаггүй.

Хувьцаа, хөрөнгө болон хувьцаа эзэмшилд гарсан өөрчлөлтийг зохицуулах хороо, албанд мэдэгдэх шаардлагууд: Аливаа томоохон өөрчлөлт (эзэмшилд 3%-ийн өөрчлөлт гарахаас эхэлнэ)-ийг Бие даасан Телевизийн Хороонд нэн даруй мэдэгдэх ёстой.

Хэвлэл мэдээллийн хэрэгслийн эзэмшилтэй холбоотой хууль тогтоомж, тусгай зөвшөөрөл олгоход тавигдах шаардлагууд, нийгмийн бүлгүүдийн төлөөлөл: Зохицуулагч алба, байгууллагад (Бие даасан Телевизийн Хороо эсвэл Радиогийн алба) нийгмийн төлөөллийг томилдоггүй. Гэхдээ эдгээр байгууллагууд нь үзэгчдийн үзэл бодлын талаар өргөн хэмжээний судалгаа хийн ач холбогдол өгч байх ёстой. Плюралист ашиг сонирхлыг хамгаалах зорилготой Радио телевизийн Маргааны комисс, Радио телевизийн стандартын комисс гэж байдаг.

Хэвлэл мэдээллийн олон төрлийн хэрэгслийн эзэмшлийн тухай дүрэм журам: Зах зээлийн 20-оос бага хувийг эзэмшдэг үндэсний сонинууд нэг хувийн радио телевиз эсвэл хиймэл дагуул эзэмшиж орон нутгийн бус хиймэл дагуулын радио телевизийг бүрэн удирдах эрхтэй байдаг. Хэвлэлийн газруудын орон нутгийн борлуулалт нь 20%-иас бага (олон нийтийн ашиг сонирхлын тестээр шалгана) бол орон нутгийн 3 радиогийн тусгай зөвшөөрөл эзэмшиж болдог. Орон нутгийн борлуулалт нь 20-50%-тай орон нутгийн сонин нэг FM радиогийн станц, нэг AM радиогийн станц эзэмшиж болно. Орон нутгийн борлуулалт нь 50%-иас дээш бол орон нутгийн сонин зөвхөн нэг орон нутгийн радио станцтай байж болно (олон нийтийн ашиг сонирхлын тестээр шалгана). Нэвтрүүлгээ газраас дамжуулдаг радио телевизүүд үндэсний сонины хувьцааны 20 хүртэлх % болон орон нутгийн бус хиймэл дагуулын тусгай зөвшөөрөл эзэмшиж болно. Тусгай зөвшөөрөл олгосон бүс нутаг болон сониноо борлуулдаг бүс нутаг хоорондоо их хэмжээгээр давхцдаггүй бол бүс нутгийн хэвлэлийн газрууд бүс нутгийн нэг радио телевиз эзэмших эрхтэй.

Радио телевизийн үзэгчдийн хувь хэмжээг 15% байхаар (радио, телевизийн аль алинд нь) хязгаар тогтоосон зах зээлийн шинэ хэм хэмжээг Хуулинд оруулжээ. Ийм учраас эзэмшил болон тусгай зөвшөөрөл нь нийлээд 15%-иас давахгүй бол компаниуд нэгээс олон тусгай зөвшөөрөл эзэмшиж болох юм. Энэхүү хэмжээг сувгийн тоон дээр бус (Герман улс шиг) компанийн эзэмшилийн хувь хэмжээ болон холбогдох үзэгчдийн хувь хэмжээн (ИТС, Радиогийн албанаас тооцон гаргадаг) дээр үндэслэн гаргадаг. Зах зээлийн төвлөрөл үүссээр байгаа хэдий ч ITV сувгууд ИБУИНВУлсын хуучин хууль тогтоомжоор бий болсон эзэмшилийн ээдрээтэй бүтэцтэй хэвээр байна. ITV-ийн сувгууд нь бүс нутгийн салбаруудад хуваагддаг бөгөөд 18 компанид тусгай зөвшөөрөл авсан байдаг. ITV-ийн эдгээр компаниудыг бусад хөрөнгө оруулагчид нь хэвлэл мэдээллийн хэрэгслийн олон төрлийг эзэмших ээдрээтэй зохион байгуулалтаар эзэмшдэг.

Аливаа хуулийн этгээд нэг бүс нутагт ITV-ийн нэгээс олон суваг эзэмшиж болохгүй. ITV-ийн тусгай зөвшөөрөл болон Channel five-ийг аль алиныг нь эзэмшихийг хориглодог. Нэг бүс нутагт нэг FM, нэг AM радио станц эзэмших хязгаарлалт байдаг. Олон нийтийн ашиг сонирхлын тестээс шалтгаалан 3 тусгай зөвшөөрөл олгож болно. Аливаа хуулийн этгээд нэгээс олон үндэсний радио станц эзэмших эрхгүй байдаг.

Гадаадын эзэмшил/хөрөнгө оруулалтын дүрэм журам: Хэвлэл мэдээллийн гадаадын эзэмшилд ямар нэг хязгаарлалт хориг байдаггүй.

Европын Холбооны суурьшилтай байгууллагуудад зөвхөн газраас нэвтрүүлэг дамжуулах тусгай зөвшөөрөл олгодог. Кабель, хиймэл дагуул эсвэл газраас дижиталаар дамжуулах тусгай зөвшөөрөлд гадаадын эзэмшилийн ямар нэг хориг хязгаарлалт байдаггүй.

Хүртээмжийг хангах тухай хууль тогтоомж: цацалтын талбай, дотоод харилцаа, үндсэн техник хэрэгсэл: Салбарыг аажмаар чөлөөлж буй Харилцаа холбооны Алба хандалт, үнэ тарифыг нөхцөл байдал тус бүрт нь тогтоодог. ИБУИНВУлс Европын энэ талаархи ONP захирамжийг хараахан хэрэгжүүлж эхлээгүй байгаа.

Өрсөлдөөний тухай хууль (ба түүнийг хэвлэл мэдээллийн хэрэгсэлд ашиглах байдал

Төвлөрлийг нийтдээ 30 саяас давсан тохиолдолд хязгаарлаж эхэлдэг. Шударга Худалдааны Алба (OFT)-аас мөрдөн байцаалтыг явуулдаг. OFT мэдээлэл өгснөөр Худалдаа, аж үйлдвэрийн яам цааш нь мөрдөн байцаалт явуулах шаардлагатай эсэхийг шийддэг. Шаардлагатай гэж үзвэл Худалдаа, аж үйлдвэрийн яамны (DTI) Монополь ба компанийн нэгдлийн хороо (MMC) цааш нь үргэлжлүүлэн мөрдлөг явуулдаг. MMC нь монополь байр суурь үүсэх эсэхийг тогтоож төвлөрлийг хаах эсвэл өөрчлөлт оруулах талаар саналаа гаргадаг. Эцсийн шийдвэрийг Парламентаас гаргадаг.

Төвлөрлийн хяналт: 1973 оны Шударга Худалдааны тухай хуулинд хэвлэл мэдээллийн төвлөрлийн талаарх тусгай заалтууд байдаг. 500,000-аас дээш өдөр тутмын борлуулалттай сонины эзэмшилийг шилжүүлэхэд Худалдаа, аж үйлдвэрийн сайдаас зөвшөөрөл авах шаардлагатай (OFT-с лавлагаа авах шаардлагагүй). Сайд мөн 50,000-аас доош өдөр тутмын борлуулалттай сонины эзэмшилийн шилжүүлгийг зогсоох эрхтэй. Шийдвэр гаргахдаа Сайд олон нийтийн ашиг сонирхлыг харгалзан үзэх ёстой (үүнийг “олон нийтийн ашиг сонирхлын тест” гэж нэрлэдэг). Практикт ийм шийдвэр мэдээж хэрэг хөндлөнгийн бөгөөд улс төрийн сэдэлтэй байх магадлалтай.

Монопольчлолыг тодорхойлох хэмжигдэхүүнүүд ба арга зам: ИБУИНВУлсын өрсөлдөөний тухай хуулийн дагуу зах зээлийн төвлөрөл нь тухайн зах зээлийнхээ 25% хүртэл байна гэсэн хязгаар байдаг.

1996 оны Радио телевизийн тухай хуулиар компаниуд радио телевизийн үзэгчдийн хувь хэмжээний нийт 15%-ийг эзэмшинэ гэсэн хязгаарлалт тогтоожээ.

Шударга худалдааны албаны ерөнхий захирал газраас нэвтрүүлгээ дамжуулдаг арилжааны телевизийн ашиг сонирхолтой холбоотой шийдвэрийг “өрсөлдөөний тест”-ийн дагуу гаргаж болно.

Хэвлэл мэдээллийн компаниудад төрийн дэмжлэг үзүүлэх, татаас олгох: Сонинууд НӨАТатвараас чөлөөлөгддөг.

Хэвлэл мэдээллийн хэрэгслийн эзэмшил ба төвлөрлийн асуудал дахь зохицуулах хороо, байгууллагуудын эрх мэдэл: Хэрвээ компанийн эзэмшилийн хязгаар хэтэргвэл ИТС буюу Радиогийн албаны аль аль нь радио телевизийнх нь тусгай зөвшөөрөлийг цуцалж болно.

Ирээдүйн зохицуулалтын санал ба чиг хандлага: ИБУИНВУлсын Хөдөлмөрийн намын засгийн газраас гаргасан радио телевизүүд болон харилцаа холбооны операторуудын хоорондох өрсөлдөөнийг зөвшөөрөх шинэ радио телевизийн тухай хуулийн төсөл хүлээгдэж байна.

Зургаа. Америкийн Нэгдсэн Улс

АНУ 1996 оны Харилцаа холбооны тухай хуулийн өөрчлөлт шинэчлэлтээс хойш төрийн зохицуулалтыг халах олон санаачлага гараад байгаа юм. Тус хуулийг 1934 оны анхны Харилцаа холбооны тухай хуулин дээр үндэслэсэн бөгөөд 62 жилийн хугацаанд уг салбарт гарсан анхны томоохон өөрчлөлт болсон юм. Телеком (кабель ба утас), Радио телевиз болон интернетийг уг салбарын “радикал өөрчлөлтүүд”-ийг хийх боломжийг бий болгосон гэж үздэг.

Одоо хэрэгжиж буй тэдгээр дүрэм журмыг дор товч дурдвал:

Сонин/Радио телевиз давхар эзэмшихийг хориглосон дүрэм (1975): Сонин/Радио телевиз давхар эзэмшлийн тухай журмаар тухайн сонины хэвлэн нийтэлдэг хот нь радио телевизийн сувгийн үйлчилгээний бүс нутагт хамаардаг бол бүрэн ажиллагаатай радио телевизийн суваг болон өдөр тутмын сонин давхар эзэмшихийг хориглодог.

Радио/телевизийн давхар эзэмшлийн хориг (1970): Радио/телевизийн давхар эзэмшлийн тухай анхны дүрэм журмаар нэг зах зээл дээрх радио болон телевизийг зэрэг эзэмшихийг хоригложээ. Одоо хэрэгжиж буй дүрэм нь нэг зах зээл дээр дор хаяж нэг телевиз ба нэг радиогийн суваг зэрэг эзэмшихийг зөвшөөрдөг. Томоохон зах зээлүүдийн хувьд тухайн зах зээл дээр хэдэн хувийн эзэмшлийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл байна гэдгээс шалтгаалан нэг хуулийн этгээд нэмэлт радио станцууд эзэмшиж болдог.

Орон нутгийн телевизийн олон хүний эзэмшлийн тухай дүрэм 1964): Орон нутгийн ТВ-ийн эзэмшлийн дүрмээр аливаа хуулийн этгээд доорх нөхцлийг хангасан

тохиолдолд нэг (Nielsen хэвлэл мэдээллийн судалгааны төвийн тодорхойлсноор) Нэрлэсэн Зах Зээлийн бүс (DMA) дэх 2 телевиз эзэмшиж болдог. Үүнд: (1) тухайн сувгийн үйлчилгээ үзүүлж буй газар нутаг нь давхцахгүй, (2) хоёр сувгийн дор хаяж нэг нь DMA дэх хамгийн шилдэг 4 сувгийн жагсаалтанд ороогүй (зах зээлд эзлэх хувь хэмжээн дээр үндэслэнэ) бөгөөд санал гаргасан нэгдлийн дараа DMA-д дор хаяж 8 хувийн эзэмшлийн арилжааны болон арилжааны бус телевизийн суваг үлдэж байх ёстой.

Хамтарсан ТВ-ийн сүлжээний дүрэм (1946): Хамтарсан сүлжээний дүрэм нь анх аливаа хуулийн этгээдийг нэгээс олон радио суваг ажиллуулахыг хориглож байв. Хэдэн жилийн дараа уг дүрэм телевизийн сүлжээг хамран өргөжсөн. Өнөөдөр хамтарсан сүлжээний дүрмээр дараах 4 телевизийн сүлжээг нэгдэхийг хориглодог: ABC, CBS, Fox, ба NBC

Орон нутгийн радиогийн эзэмшлийн тухай дүрэм (1941): Холбооны Харилцаа холбооны Хорооноос (FCC) гаргасан орон нутгийн радиогийн эзэмшлийн дүрэм нь анх ижил газар нутагт нэвтрүүлэг цацдаг ижил үйлчилгээний радио сувгуудыг (AM ба FM) зэрэг эзэмшихийг хориглодог байв. Өнөөдөр FCC-ийн орон нутгийн радиогийн эзэмшлийн дүрмээр дараах хоригуудыг тавьдаг. Үүнд: (1) 45 ба түүнээс олон арилжааны радио суваг бүхий радиогийн зах зээл дээр нэг нам 5-аас илүүгүй нь нэг үйлчилгээний хүрээнд байдаггүй 8 хүртэлх тооны арилжааны радио эзэмших, ажиллуулах буюу удирдаж болно; (2) 30-44 арилжааны радио суваг бүхий радиогийн зах зээл дээр нэг нам 4-аас илүүгүй нь нэг үйлчилгээний хүрээнд байдаггүй 7 хүртэлх тооны арилжааны радио эзэмших, ажиллуулах буюу удирдаж болно; (3) 15-29 арилжааны радио суваг бүхий радиогийн зах зээл дээр нэг нам 4-аас илүүгүй нь нэг үйлчилгээний хүрээнд байдаггүй 6 хүртэлх тооны арилжааны радио эзэмших, ажиллуулах буюу удирдаж болно; (4) 14 ба түүнээс цөөн арилжааны радио суваг бүхий радиогийн зах зээл дээр нэг нам 3-аас илүүгүй нь нэг үйлчилгээний хүрээнд байдаггүй 5 хүртэлх тооны арилжааны радио эзэмших, ажиллуулах буюу удирдаж болох ба харин тухайн зах зээл дээрх сувгуудын 50-иас илүү хувийг нэг нам эзэмших, ажиллуулах буюу удирдаж болохгүй.

Үндэсний ТВ-ийн эзэмшлийн тухай дүрэм (1941): FCC 1941 онд телевизийн нэвтрүүлгийн сувгуудын улсын эзэмшлийн хориг хязгаарлалтыг анх батлахдаа зэрэг эзэмшиж болох сувгийн тоон дээр олон тооны хязгаар тогтоосон юм. Үүний дараа зөвшөөрөгдсөн хэмжээг нэмэгдүүлэхийн тулд уг дүрмийг олон удаа өөрчлөн шинэчилсэн юм.

Өнөөдрийн байдлаар үндэсний ТВ-ийн эзэмшлийн тухай дүрмээр аливаа хуулийн этгээдийг АНУ-ын телевиз үзэгч айл өрхийн 39-өөс дээш %-д хүрдэг телевизийн суваг эзэмшихийг хориглодог. “Хүрэх” гэдгийг эзэмшлийн суваг бүрийг хуваарилсан ТВ-ийн Нэрлэсэн Зах Зээлийн бүс (DMA) дэх телевиз үзэгч айл өрхийн тоо гэж тодорхойлдог. DMA дэх айл өрх бүхэн маш өндөр давтамжийн (VHF) станцуудад хамаардаг бөгөөд DMA дэх айл өрхүүдийн 50% нь хэт өндөр давтамжийн станцуудад (UHF) хамаардаг.

Ийнхүү дээрх хэлэлцүүлгийн үр дүнд төвлөрлийн тухай дүрмийг нэлээд сулруулах ба FCC-ээс 2003 оны шийдвэрүүддээ гаргасан олон санал санаачилгыг баталгаажуулж байна. Одоогоор ямар нэг бодитой арга хэмжээ аваагүй байгаа нэг салбар бол Радио телевизийн **Гадаадын эзэмшлийн** асуудал юм. АНУ-д кабель, хиймэл дагуул, хэвлэл буюу Телекомийн үйлчилгээн дэх гадаадын эзэмшлийн талаар ямар нэг дүрэм байдаггүй боловч радио телевизийн гадаадын хөрөнгө оруулалт нь тусгай зөвшөөрөл эзэмшигчийн сонгох хувьцааны 25%-иас ихгүй байх ёстой. Төрийн оролцоог халахыг дэмжигчид зах зээлийн бодит байдал ба хэвлэл мэдээллийн хэрэгслийн талаар гарч ирж буй шинэ байр суурийг дээрх нөхцөл байдал тусгаж чадахгүй байна гэж үздэг.

Долоо. Австрали улс

Хэвлэл мэдээллийн хэрэгслийн Эзэмшил ба Олон талт үзлийн талаарх маргаан Австрали улсад арав гаруй жил хүчтэй өрнөж байна. Үүнийг олон тооны судалгаа, хүчтэй үзэл бодол, сонирхлын бүлгийн мэтгэлцээн болон хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийн давхар эзэмшил ба телевизийн сувгуудын гадаадын эзэмшилийг чөлөөлөх тухай шинэ хууль тогтоомж гаргах гэсэн бүтэлгүй оролдлогуудаас харж болно. Шинэ техник технологид шинэ хууль журам шаардлагатай шинэ хөтөлбөр бий болсон нь маргааныг улам хурцатгасан байна. Ингээд эцэст нь 2007 оны 4-р сарын 4-нд 1992 оны Радио телевизийн үйлчилгээний тухай хуулийн өөрчлөлт шинэчлэлтийг баталсан бөгөөд шинэ дүрэм журам, процесс хэрэгжиж байна.

Телевизийн эзэмшил: Тусгай зөвшөөрөлийн нийт хамрах хүрээ нь Австрали улсын нийт хүн амын 75-аас дээш хувийг хамарсан телевизийн тусгай зөвшөөрөлийг эсвэл тусгай зөвшөөрөл бүхий газар нутагт нэгээс олон тусгай зөвшөөрөлийг хувь хүн эзэмших эрхгүй байдаг. Гадаадын иргэд тусгай зөвшөөрөлийг удирдах албан тушаал хаших ёсгүй бөгөөд гадаадын нийт хувь оролцоо 20%-иас хэтэрч болохгүй. Мөн нийлмэл удирдлага, гадаад захирлуудын талаар лимит хязгаарлалт байдаг.

Радиоогийн эзэмшил: Тусгай зөвшөөрөлийн хамрах хүрээ нь ижил газар нутагт хувь хүн 2-оос дээш тооны тусгай зөвшөөрөл эзэмших албан тушаал хашиж болохгүй. Мөн нийлмэл удирдлагын талаар лимит хязгаарлалт байдаг.

Хэвлэлийн эзэмшил: Хэвлэл нийтлэлийн салбарын дотоодын эзэмшилийг зохицуулах цөөн хэдэн дүрэм байдаг, гэхдээ давхар эзэмшилийн талаар нилээд хатуу хоригууд байдгийг дор дурдав.

Олон улсын хэвлэл мэдээллийн хэрэгслийн хязгаарлалт: Дээр дурдсан хуулийн дагуу хувь хүн:

- Тусгай зөвшөөрөлийн хамрах хүрээ нь ижил газар нутагт арилжааны телевизийн тусгай зөвшөөрөл ба арилжааны радиоогийн тусгай зөвшөөрөл эзэмших
- Арилжааны телевизийн тусгай зөвшөөрөл ба тусгай зөвшөөрөлийн хамрах хүрээтэй нь холбоотой сонин эзэмших
- Арилжааны радиоогийн тусгай зөвшөөрөл ба тусгай зөвшөөрөлийн хамрах хүрээтэй нь холбоотой сонин эзэмшихийг тус тус хориглодог.

Мөн хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийг давхар удирдах талаар лимит хязгаарлалт байдаг.

Хэрэглэгчийн Телевизийн тусгай зөвшөөрөл: Хэрэглэгчийн радио телевизийн тусгай зөвшөөрөлийн хувьцааны 20-иос дээш %-ийг гадаадын иргэн эзэмших эрхгүй бөгөөд гадаадын компаний нийт хувь хэмжээ нь 35%-иас хэтрэх ёсгүй.

Найм. Шинэ Зеланд

Гадаадын эзэмшилийн тухай дүрэм, хэвлэл мэдээллийн хэрэгслийн давхар эзэмшлийн хориг гэж байдаггүй.

Шинэ Зеланд улс нь хүн ам цөөтэй (4 сая хүн) бөгөөд газарзүйн хувьд хамгаалагдсан зах зээл гэж үзэж болно. 80, 90-ээд оны үед Шинэ Зеландын засгийн газраас авч хэрэгжүүлсэн арга хэмжээнүүд нь олон талаараа тусгаарласан зах зээлийн туршилтыг бий болгожээ. Хэвлэлийн болон радио телевизийн олон компаниудын эзэд нөхцөл байдалд сэтгэл хангалуун байдаг бөгөөд уг системийг тууштай хамгаалдаг. Харин үндэсний соёлын үзэлтнүүд, судлаачид, сэтгүүлчид орон нутгийн илүү сайн мэдээг бий болгож, үзэл бодлоо илэрхийлэхийн тулд илүү зохицуулалттай орчин нөхцлийг бий болгон өөрчлөхийг дэмжиж байгаа юм.

Улстөрчид хүртэл ямар нэг зүйл хийх хэрэгтэй гэж үзэж эхэлж байна. 1990-ээд оны дундуур Үндэсний намын засгийн газрын Шинэ Зеланд радиог хариуцсан сайд хэлэхдээ:

“Бид үнэхээр Шинэ Зеландчууд эзэмшдэг, Шинэ Зеландынх гэсэн содон суваг, хөтөлбөртэй болохыг хүсч байна, манай бүх сувгуудыг ноён Мурдок эзэмшдэг байхыг би хүсэхгүй байна.....” гэжээ.

Төвлөрөл болон гадаадын эзэмшлийн тухай асуудлыг Засгийн газар эдгээр санал санаачилгаараа гаргаж тавихыг оролдож байгаа ч тэд бүтэц зохион байгуулалтгүй бөгөөд Шинэ Зеландын харилцаа холбооны сектор гадаадын эзэмшилд, маш ихээр төвлөрсөн хэвээрээ байна.

Ес. Австри

Австри улсын хувийн болон улсын радио телевизүүдийн тусгай зөвшөөрөл, захиргаа, техник технологи, санал гомдол зэргийг зохицуулдаг зохицуулагч байгууллага нь Komm-Austria юм. Олон нийтийн радио телевиз ORF-ийг удирддаг Холбооны Харилцаа холбооны зөвлөлд тус байгууллага ажлаа тайлагнадаг. Телекомын асуудлуудыг хариуцаж радио телевизийн Холбооны канцлер болон харилцаа холбооны хэрэгслийн Сайдад ажлаа тайлагнадаг RFR нэртэй холбооны өөр нэг байгууллага нь Komm-Austria-г захиргааны хувьд дэмжин ажилладаг.

Өнгөц харахад энэ бүхэн эзэмшил ихээр төвлөрсөн жижиг улсын хувьд дээд захиргаа ихтэй санагдаж магад. 1997 он хүртэл хувийн радио, телевиз гэж бараг байгаагүй бөгөөд 2003 оноос л хувийн ТВ-н сүлжээ бий болж эхэлсэн гэдгийг тэмдэглэх нь зүйтэй. ORF олон нийтийн радио телевиз болон сонины эзэмшигчид удаан хугацааны туршид зах зээлийг эзэлж байсан бөгөөд одоо ч зохицуулалт хийгдсээр байна. Хэвлэл мэдээлэлд зориулсан зохицуулах орчин байдаггүй хэдий ч Хэвлэл мэдээллийн хэрэгслийн тухай хуульд заасан стандартыг дагаж мөрддөг (садар самуун сонин сэтгүүл, хүчирхийлэл г.м)

Радио, Телевизийн эзэмшил: Аливаа хуулийн этгээд үйлчилгээний аль ч бүс нутагт нэгээс олон радиогийн эсвэл ТВ-ийн тусгай зөвшөөрөл эзэмшиж болохгүй. Нэг нэгнийхээ хувьцааны 25-аас дээш %-ийг эзэмшдэг хэвлэл мэдээллийн конгломератууд нэгээс олон төстэй буюу дижитал ТВ-ийн тусгай зөвшөөрөл эзэмшихийг хориглодог. Уншигчдад дахин сануулахад арилжааны ТВ, радиогийн салбар үүсээд 10 хүрэхгүй жил болж байгаа бөгөөд хөгжлийнх нь энэ үе шатанд түүнийг дөнгөж үүсч буй гэж тооцдог. Хэдэн арван жил монополь байсан ORF цахим зах зээлд давамгайлсан хэвээрээ байгаа бөгөөд тусдаа дүрэм журмаар зохицуулагддаг.

Радио нь зөвшөөрөл тусгай зөвшөөрөлийн хувьд ТВ-тэй төстэй боловч нэг ялгаа байдаг нь үйлчилгээний хамрах хүрээ нь давхцахгүй бол өөр хэвлэл мэдээллийн компани радиогийн тусгай зөвшөөрөлийг 100% эзэмшиж болдог.

Сонины эзэмшил: Картелийн тухай хуулиас өөр ямар нэг хориг зохицуулалт байдаггүй.

Гадаадын эзэмшил: Европын Эдийн засгийн бүсийн бус гишүүдээс (ихэнхи нь Европын Холбооны орнууд) хамгийн ихдээ 49%-ийн хөрөнгө оруулалт авч болно.

Улс төрийн нам, байгууллагуудын хязгаарлалт: Тэдэнд Радио, ТВ-ийн тусгай зөвшөөрөл эзэмшихийг хориглодог.

Тав. ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГСЛИЙН ЭЗЭМШИЛ, ТӨВЛӨРЛИЙН ТАЛААРХИ ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧНЫГ БҮРДҮҮЛЭХЭД ЧИГЛЭГДСЭН ЗӨВЛӨМЖ, САНАЛ ДҮГНЭЛТ

Хэвлэл мэдээллийн хэрэгслийн эзэмшил, түүний зах зээлд эзлэх хувийг харуулах төвлөрлийн асуудал нь орчин үеийн хэвлэл мэдээллийн зах зээл, нийгэмд тулгамдсан асуудал болж харагдах болсон. Хэвлэл мэдээллийн хэрэгслийн эзэмшил нь нэг буюу хэд хэдэн арга замаар зах зээлд төвлөрөх үед дараахь үр дагаварт хүрдэг байна:

- Илүүтэй ашгийн сонирхлыг төрүүлж, олон нийтийн эрх ашгаас урьтан спонсорууд, зар сурталчилгаа үйлдвэрлэгчид болон засгийн газарт илүү ойртон, хэвлэл мэдээллийн хүчирхэг зах зээлийг хөтлөж, удирдаж эхэлдэг байна.
- Хэрэв хэдхэн цөөхөн компаниуд 300 сая америк иргэдийг хянах цөөнхийн ашиг сонирхлыг илэрхийлээд эхэлбэл, тэднийг “олон нийтийн долгион” гэж нэрлэх зөвхөн хуурмаг үйлчилгээ болон хувирна.
- Өрсөлдөөнд тулгуурласан зах зээл байхгүй болж, нээлт, шинэлэг байдал буурч, үнэ өснө.

Олон талт мэдээллийг тодорхой зах зээлд хүргэснээр хэвлэл мэдээллийн төвлөрөл, түүний үр нөлөөг боловсронгуй болгох нь чухал байдаг. Төвлөрлийн талаархи шүүмжлэл нь үндэсний хэвлэл мэдээллийн зах зээлийг хянагч монополууд, эсвэл олигополууд олон нийтийн ашиг сонирлолд бүрэн хамаарч, тооцож чадах уу гэсэн асуудлыг гаргаж ирдэг.

Түүнчлэн хэвлэл мэдээллийн хэрэгслийн төвлөрлийн асуудал нь улс төрийн эсэргүүцэлтэй тулгарах явдал аль ч улсад, бүр Европын холбооны хувьд ч гарч байсан учир судалгааг хийх, хуульчлах асуудал багагүй эсэргүүцэлтэй тулгардаг байна.

Ил тод байдлыг зарим тохиолдолд хэвлэл мэдээллийн хэрэгсэлд олон ургалч үзлийг бий болгох зорилгод хүрэх зорилт, зарим тохиолдолд түүнд хэрэглэгдэх арга зам гэж үздэг.

Хэрэглэгч буюу олон нийтийн мэдээллийн хэрэгслийн хэрэглэгч нь хамгийн их мэдээлэл бүхий сонголтыг хийхийн тулд бүтээгдэхүүний тухай, мөн түүнийг үйлдвэрлэгч, ханган нийлүүлэгчийн ерөнхий мэдээлэл, ашиг сонирхол зэргийн талаар аль болох их зүйл мэдэх хүсэлтэй байдаг.

Зарим тохиолдолд хэвлэл мэдээллийн хэрэгслийн зах зээлд тодорхой хэмжээгээр хөндлөнгөөс оролцох шаардлагад анхаарал хандуулбал олон нийтийн ашиг сонирхол нь бодит байдал дээр эрх мэдлийн үнэлгээтэй холбоотой байх ёстой. Жишээлбэл, чухамдаа хэн удирдаж байгааг нь мэдэлгүйгээр компаний эсвэл бүлэг компаниудын үйл ажиллагааг зохицуулах буюу хөндлөнгөөс оролцох нь утгагүй юм.

Гэхдээ ерөнхийдөө ил тод байдлын хэмжээ, хүрээ нь тухайн улс орны удирдлагын улс төрийн идэвх чармайлтаас нэлээд шалтгаалдаг.

Олон улс орон компанийн нэрийг сонинд гаргасан байхыг зайлшгүй шаардлага болгодог ч ингэснээр жинхэнэ ил тод байдлыг бий болгож чаддаг эсэх нь эргэлзээтэй. Олон тохиолдолд компаний нэр нь тухайн бүтээгдэхүүний цаадах жинхэнэ ашиг сонирхлын тухай ихийг илэрхийлж чадахгүй бөгөөд тийм мэдлэгийг олж авахад нэлээд их хүчин чармайлт гаргах шаардлагатай болж мэднэ. Зарим улс орон борлуулалтын эсвэл тухайн хэвлэл мэдээллийн бүтээгдэхүүний хүртээмжийн тухай мэдээллийг бүтээгдэхүүндээ багтаасан байх шаардлага тавьдаг.

Дижитал аргаар (Интернет, газраас нэвтрүүлгээ дижиталаар эсвэл хиймэл дагуулаар цацах, бусад төрлийн сүлжээнүүд) түгээх шинэ хэлбэрүүд үүссэнээс шалтгаалан тусгай зөвшөөрлийн систем нь бүхэлдээ удаан оршин тогтнох боломжгүй байж магадгүй. Эдгээр хөгжил дэвшил нь бидний мэдэх “суваг” гэсэн ойлголтыг үгүй болгож ил тод байдлын нөхцлийг үндсээр нь өөрчилж мэднэ.

Хэрэв ил тод байдал нь эрх мэдлийг үнэлэх, эрх мэдлийн бүтэц зохион байгуулалтанд нөлөөлөх арга хэрэгсэл юм бол сонирхогч талууд компаниудаас мэдээллээ ил болгохыг үүрэг болгосон албан ёсны дүрэм журман дээр найдаж болохгүй. Мэдээллийг идэвхтэй эрж хайх ёстой бөгөөд олон тооны арга замыг ашиглах ёстой. Судалгаа бол тийм нэг арга зам бөгөөд шинжлэх ухааны судалгаа болон мэдээлэл, баримт бичиг цуглуулах аргын аль аль нь болно. Ийм судалгаа шинжилгээний үр дүнд мэдээллийн бааз, бүртгэл, статистик, олон төрлийн хэвлэл нийтлэл, харьцуулалтын схем г.м зүйлс үүсдэг. Европын Холбоо удирдамж гаргах бэлтгэл ажлынхаа хүрээнд бүх гишүүн орон өөрийн хил доторх хэвлэл мэдээллийн хэрэгслийн эзэмшлийн асуудлыг **үнэлэх, хянах чадвартай** байх ёстой гэсэн урьдчилсан шаардлага гаргасныг дурдах нь зүйтэй.

Европын ихэнх орнууд радио телевизийн салбарт өрсөлдөөн ба/эсвэл олон ургалч үзлийг бий болгохын тулд эзэмшилд тодорхой хэмжээгээр хязгаарлалт хийх зохицуулагч алба байгуулсан байдаг. Эдгээр орнуудаас дурдвал: Бельги, Герман, Франц, Итали (телеком компаниудыг мөн хянах шинэ алба байгуулах явцдаа байгаа), Норвеги (мөн хэвлэл мэдээллийн хэрэгслийн олон ургалч үзлийн алба байгуулж байгаа), Португал (Alta Autoridade гэсэн байгууллагатай), Их Британи (хүчирхэг байгууллагуудтай). Зүүн болон Төв Европын ихэнх орнууд тусгай зөвшөөрөлийн хуваарилалтыг хариуцдаг радио, телевизийн “зөвлөл”-тэй байдаг.

Хэвлэл мэдээллийн зохицуулалтыг ихэвчлэн бусад олон нийтийн байгууллагаас хянадаг (Франц, Их Британий хувьд), харин бусад орнуудад (Норвеги, Итали)

Монгол Улсын хууль тогтоомжийг боловсронгуй болгох талаар:

1. Төвлөрөл гэх ойлголтыг Монгол Улсын Өрсөлдөөний тухай хуульд тодорхойлсон боловч хэвлэл мэдээллийн хэрэгслийн эзэмшлийн эзлэх хувь зах зээлд ямар хувь хэмжээнд хүрсэн тохиолдолд төвлөрөл гэх ойлголтод хүрдэг эсэхийг тодорхой заах хэрэгтэй.
2. Ил тод байдал, олон ургалч үзэл гэсэн ойлголтууд нь мэдээлэл авах эрхийг хангах гол түлхүүр болох тул хэвлэл мэдээллийн хэрэгслийн эзэмшигчдийг тусгай зөвшөөрлөө авах үед нь дэлгэх шаардлагыг хуульчилж, олон нийтэл ил болгох шаардлагатай.
3. Харилцаа холбооны зохицуулах газар болон Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын зохицуулах чиг үүргийг уялдуулах, тодорхой болгох
4. Зах зээлд эзлэх хувийг Монгол Улс дахь хэвлэл мэдээллийн зах зээлийн хөгжил, үзэгч, хэрэглэгч, газар нутгийн байршилтай уялдуулах харилцан адилгүй тогтоох учир Харилцаа холбооны зохицуулах газраас тодорхой стандартууд гарган, хэвлэл мэдээллийн хэрэгслийн төвлөрлийг тогтоох, зохицуулах боломж олдоно.
5. Гадаад эзэмшлийн хувьд энэ нь нэлээд “эмзэг” ойлголт байж болох боловч тухайн улсын үндэсний аюулгүй байдалд ч нөлөөлж болох ойлголт гэдгийг анхааруулах үүднээс зарим улсад хориглодог, хязгаарладаг ойлголт юм. Харин Монгол Улсын хувьд зах зээлийн судалгаа, хэрэглэгчийн тоо, эзлэх хувийг тогтоосны үндсэн дээр гаргах учир хууль тогтоомжийн хүрээнд хориглох шаардлагыг шууд тогтоох боломжгүй юм.
6. Хууль тогтоомжийг боловсронгуй болгох гэсэн асуудал нь хориглох гэхээсээ илүүтэй, тогтоох, тодорхойлох, зохицуулах, хянах системийг хамгийн зохимжтой байдлаар тусгаснаар Ил тод байдлыг олж авах боломж бүрдэх юм.
7. Эзэмшлийн тухай бие даасан хуультай байх нь Өрсөлдөөний хуулинд “найдаж” суух идэвхигүй байдлыг засах боломжтой юм. Хэвлэл мэдээллийн хэрэгслийн эзэмшлийн тухай хууль нь зах зээлийн төвлөрлийг зохицуулах боломжгүй болох үед мэдээж хэрэг Өрсөлдөөний тухай хуулийг мөрддөг практик түгээмэл байна.
8. Зах зээлд үзэгчдийн тоо, орлогын хэмжээ, зах зээлд эзлэх хувь, нэг бүс нутаг дахь хэд хэдэн хэвлэл мэдээллийн хэрэгслийн эзэмших гэсэн түлхүүр 4 ойлголтоор бид хэвлэл мэдээллийн хэрэгслийн эзэмшил, төвлөрлийг ойлгон зохицуулах боломжтой юм.
9. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын талаархи шинэчилсэн үзэл баримтлал болон зөвлөмж, холбогдох баримтуудаар Монгол Улс дахь хэвлэл мэдээллийн хэрэгслийн эзэмшлийг ил тод болгоно гэдгийг зөвшөөрч баталгаажуулж байгаа нь сайшаалтай байна. Гэвч үүнийг ил тод болгох шалгуур, зах зээлийн судалгаанд үндэслэсэн зохицуулалт хамгийн чухал юм.

ⁱ 3.2.2.2. Гадаадын аль нэг орноос хийгдэх хөрөнгө оруулалтын хувь, хэмжээг гадаадын нийт хөрөнгө оруулалтын **гуравны нэгээс** хэтрэхгүй байлгах бодлого баримтална. Гадаадын төрийн өмчит компанийн хөрөнгө оруулалтыг хязгаарлаж, стратегийн ач холбогдолтой салбарт хөрш орон, өндөр хөгжилтэй бусад орноос оруулах хөрөнгө оруулалтын хэмжээг тэнцвэртэй байлгах бодлого баримтална.